

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-32

<i>1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	7-18
<i>2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	18-29
<i>3.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	29-30
<i>4.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлт</i>	30-32
<i>5.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	32

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
03 дугаар сарын 20-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 59 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, Л.Мөнхбаатар, Ж.Сүхбаатар, Б.Энхбаяр;
Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд, Б.Энх-Амгалан.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ц.Мөнхцэцэг, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их

Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Л.Батмөнх, М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлтийн талаар Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд “сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй.” гэж 29.3.3 дахь заалт нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд “сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй.” гэж 29.3.3 дахь заалт нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “... Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 55 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 12 цаг 54 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
10 цаг 59 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлбэ. Чуулганы хаврын чуулган бас эхлээд анхны ХЗБХ-ны хурал маань эхэлж байна. Тэгээд энэ чуулганы үеэр бид нар бас олон чухал асуудлуудыг хэлэлцэж, цаг тухайд нь ярьж батлах хэрэгцээтэй байж байгаа. Яагаад гэвэл дараа 126 гишүүнтэй Их Хурал орж ирнэ. Энэний Дэгийн тухай хууль эд нар гээд манай Байнгын хороогоор орж ирэх бол бас нэлээн олон хуулиуд байгаа. Тэгэхээр эхнээсээ нэлээн ачаалалтай ажиллана гэдгийг бас гишүүддээ сонордуулж дуулгамаар байна. Бүгдээрээ тэгээд идэвхтэй оролцоорой гэдэг энэ хүсэлтийг тавимаар байна.

Ингээд өнөөдрийн асуудалдаа орёе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ХЗБХ-ны 24 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Цогтбаатар юу, Амартүвшин гишүүн ирсэн байна. Норовын Алтанхуяг гишүүн ирсэн байна. Бат-Амгалан гишүүн ирсэн байна. Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн байна. Дашидондогийн Ганбат гишүүн ирсэн байна. Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн ирсэн байгаа. Цэндийн Мөнх-Оргил гишүүн ирсэн байна. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн ирсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн байна. Шатарбалын Раднаасэд чөлөөтэй байгаа. Цэдэвийн Сэргэлэн гишүүн ирсэн байна. Ням-Осорын Учрал гишүүн ирсэн байна.

Ингээд ирц хүрсэн байгаа учир хуралдаан сая нээлээ. Ингээд ирцийг танилцууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр нийт 6 асуудал хэлэлцэхээр байгаа. 1 дүгээр асуудал Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Хэлэлцэх эсэхийг өнөөдөр ярина. Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил нарын гишүүд 2024 оны 3 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн байгаа. 2 дугаар асуудал Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, бас Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил нарын гишүүд 3 дугаар сарын 4-нд, энэ оны 3 дугаар сарын 4-нд өргөн мэдүүлсэн хууль байгаа. Энэ ингээд хэлэлцэх эсэх асуудлыг нь шийднэ. 3 дугаар асуудал Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн, Их Хурлын дэд дарга Одонтуяа нарын 19 гишүүн 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн байгаа. Өнөөдөр хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. Тэгээд 4 дүгээр асуудал бол “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын юу тогтоолын төсөл байгаа. 5 дугаар асуудал Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 24 оны 2024 оны 1 дүгээр сарын дүгнэлт байгаа. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай асуудал байгаа. 6 дугаар асуудал Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Энэ цаглавар батлах тухай асуудал байж байгаа. Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал саналаа өгнө үү? Ганбат гишүүнд микрофон өгье.

Д.Ганбат: Манай ХЗБХ бол маш чухал Байнгын хороо. Хууль

тогтоогчдын хууль тогтоох энэ ард түмний төлөөллийн байгууллага болсон энэ Улсын Их Хурлын уураг тархи, гал зуух гэж болохоор ийм Байнгын хороо. Их олон асуудал, олон ажил, олон хуулийг бид нар хэлэлцэнэ гэж ойлгож байна. Энэ зөв, зөв. Бид нар нойр хоолгүй бас ч чадлаараа л ажиллах ёстой л гэж бодож байна. Гэхдээ манай улс орны нөхцөл байдал ямар байна вэ? Гишүүд бид нар бүгдээрээ л бас хөдөө гадаа явж ажиллалаа, бас ард иргэдтэйгээ уулзлаа. Нөхцөл байдал бол туйлын хүнд байна. Гэтэл бид нар баахан л нөгөө нэг энэ дарга цэрэг нартай хамаатай нэг тийм байгууллагын хууль ингээд л хэлэлцээд яриад байх шаардлага ямар байна вэ?

Яг өнөөдрийн иргэдийн амьдрал ахуйд нөлөөлөх нийцэх энэ дээр нь буусан ийм хуулиудыг ярихгүй бол түрүүчээсээ Сүхбаатар аймагт чинь хамаг малаа алдчихсан хүмүүс амиа хорлоод эхэлж байна гэсэн ийм мэдээлэл явж байна. Нөгөө талаар бол энэ авлигачид чинь дийлдэхээ байчихсан байна. Нэг хуулийг чангаруулаад, хариуцлага тооцдог боллоо гэж бид нар яриад байдаг. Үнэн хэрэг дээрээ Хөгжлийн банк, энэ ногоон автобус тэр авлигын индексээр ухарсан, ардчиллын индексээр ухарсан ийм үзүүлэлттэй л байгаад байна шүү дээ. Нэг нам олонх болоод ажилласан ийм 8 жилд. Гэтэл ерөөсөө тэр хамгийн том хулгайчтайгаа, хамгийн мянганы ч гэнэ үү бараг л ингээд гадуур дотуур яриад байдаг тэрэнтэйгээ хариуцлага тооцох, энэ иргэдийн зүй ёсны шаардлага болох энэ авлигатай тэмцэх энэ талаар ямар юм байна вэ, энийг л олон нийт хүсээд байна шүү дээ. Энэ ядуурал чинь 30, 40 хувь байсан бол одоо 50 хувь руу очиж байна. Энэ хариуцлага алдаж байгаа албан тушаалтнууд энэ хүмүүстээ одоо өнөөгийн нөхцөл байдалд энэ ХЗБХ, Улсын Их Хурлаас ямар арга хэмжээ авч яаж ажиллах юм бэ? Бид нар дүлий дүмбэ оргиод л энд баахан л болсон, болоогүй хууль батлаад л ингээд л байгаад байдаг. Тэр ард ард түмний эрх ашигт нийцсэн, тэр хүсэн хүлээгээд байгаа энэ хууль, эрх зүй энэ юмыг бий

болгох энэ тал дээр анхаарч ажилламаар байх юм. Энэнтэй холбогдсон ямар хууль байна вэ? Тэрийг өнөөдрөөс эхлээд ярилцаж болохгүй юу гэсэн ийм санал байна.

Д.Цогтбаатар: Тэгэхээр яг өнөөдрийн одоо хэлэлцэх бол асуудал дээр бол байхгүй. Ерөнхий та энэ нөгөө чуулганы хугацааны асуудлыг ярьж байна. Би тантай санал нэг байна. Энд одоо яг энэ тулгамдсан асуудлуудаар бол нэлээн бид нар анхаарч ажиллах ёстой. Гэхдээ манай ХЗБХ-н дээр бол яах аргагүй зудтай холбогдсон асуудалтай эрх зүйн хувьд ямар нэгэн хүндрэл юм гарч байгаа бол Ганбат гишүүнээ шууд тийм хуулиа санаачлаад орж ирэхэд би өөрөө дэмжээд хамтраад ажиллаад явъя. Өөр нөгөө талаасаа энэ нөгөө Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо яг өнөөдрийн энэ тулгамдсан тэр зуд турхантай холбогдсон асуудлууд дээр бол бас энэ өөрсдөө саналаа хэлээд очоод тэн дээр юу тулгамдаж байна, анхаарлаа тавиад явах эрх нь бол гишүүд бид нарт байж байгаа. Хоёулаа энэ дээр ч гэсэн анхаарч ажиллая.

Авлигын тухай асуудал дээр бол яг зөв. Энэ дээр бол энэ нөгөө Шүүх байгуулах тухай хууль орж ирж байгаа. Ер нь шүүхтэй холбоотой нэлээн хэдэн хуулиуд орж ирнэ. Авлигын тухай асуудал бол эцсийн шийдвэрүүд бол шүүх дээрээ л гарч байгаа учраас энэ дээрээ бид нар ер нь бол нэлээн анхаарч ажиллах ёстой. Би сая завсарлах хугацаанд бас Дээд шүүх дээр очиж уулзалтууд эд нар хийж ажиллаж байсан. Нэг их чухал яригдаж байгаа юм энийг бас манай ХЗБХ-ныхон явц дундаа дэмжээд өгөх хэрэгтэй. Энэ нөгөө шүүхийн ил тод байдлыг бүрэн хангаж өгөх тал дээр бас нэлээн зарим хуулиуд дээр өөрчлөлтүүд бол оруулж өгөх хэрэгтэй юм байна лээ. Тэгэхгүй бол хамгийн том авлигын шүүх хурал хэлэлцэх гэж байхад нээлттэй хэлэлцэх үү, үгүй юу гээд л маргаад суучихсан шүү дээ. Тэгээд нээлттэй байх ёстой шүү дээ. Тэгэхээр энэ юмнуудыг нь

бол хангаж өгөх тал дээр энэ хуулийн төслүүд орж ирэх ёстой. Энэ дээр нь бол санаачилгатай ажиллана. Ганбат гишүүн бас дэмжээд өгөөрэй гэж хүсмээр байна. Тэгэхээр энд тэр авлига эд нартай холбоотой энэ асуудлууд дээр бол яг манай ХЗБХ-гоор бол орж ирж байгаа хуулиуд бол яг энэтэй шууд холбоотой хуулиуд орж ирнэ. Энийгээ хэдүүлээ цаг тухайд нь яриад дэмжээд явъя гэж бодож байна. Тэгвэл ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудлыг бол өөр санал байхгүй бол хэлэлцэх асуудлаа баталлаа.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

1 дүгээр асуудалдаа оръё. Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил нарын 2024 оны 3 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлын хэлэлцүүлгийг явуулъя. Ингээд төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил танилцуулна. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

ХЗБХ-ны 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Монгол Улсын ҮХЦ-ийн тухай, ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахлан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг, Баатарбилэг, Батсуурь, Бямбацогт, Сандаг-Очир, Энхбаяр нар ажиллаж,

хуулийн төслүүдийг боловсруулан Улсын Их Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Монгол Улс 1992 онд нийгэм, улс төрийн шинэ тогтолцоонд шилжиж түүхэндээ анх удаа Монгол Улсын ҮХЦ нэртэй Үндсэн хуулийн шүүхтэй болсон бөгөөд Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийг 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр баталсан. Хууль батлагдсанаас хойших хугацаанд зарим нэмэлт, өөрчлөлт орсныг эс тооцвол Үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь зарчим, нийгмийн хөгжлийн чиг хандлага эрх зүйн шинэтгэлийн үйл явцтай уялдан дорвитой өөрчлөлт хийгдээгүй явж ирсэн. ҮХЦ-ийн тухай хуулийг анх 23 зүйлтэй баталж байсан ч өнгөрсөн хугацаанд 12 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж өнөөдрийн байдлаар 13 зүйл нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Өнгөрсөн 32 жилийн хугацаанд Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаанд гарч буй өөрчлөлт, хөгжлийн хурдац, нийгмийн хэрэгцээг дагаж шүүх эрх мэдлийн бусад байгууллагын нэгэн адил Цэцийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг шинэчлэн боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна гэж ХЗБХ үзэн тодорхой үүрэг өгч ажлын хэсэг байгуулсан.

Ажлын хэсэг 30 гаруй жилийн алдаа оноог дүгнэн цэгнэж, дэлхий дахинаа төлөвшин хөгжиж буй Үндсэн хуультай ёс, Үндсэн хуулийн шүүхийн өсөн нэмэгдэж буй үүрэг хүний эрхийг тодорхой тохиолдолд хамгаалах хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн өнгөрсөн 2 жил хагасын хугацаанд тасралтгүй ажиллаж хуулийн төслүүдийг боловсрууллаа. Ажлын хэсэг ҮХЦ, Улсын дээд шүүх, ХЗДХЯ, УЕП, Улсын Их Хурлын Тамгын газар эрдэмтэн судлаачдыг оролцуулан ажлын дэд хэсгийг байгуулан мэргэжил арга зүй зохион байгуулалтын туслалцаа авсан. Ажлын хэсгийн зүгээс Монгол Улсын ҮХЦ-ийн тухай болон ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд тулгамдаж буй асуудлыг тодруулж, эрдэмтэн судлаач, хуульч

нартай зөвлөлдөж, хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор хэд хэдэн ажил зохион байгуулсан.

Тухайлбал Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг ХЗБХ, ХЗДХЯ, ҮХЦ, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан бол ХЗБХ, ХЗДХЯ, МУИС-ийн үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнтэй хамтран ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчлэл хэлэлцүүлгийг хуульчдын дунд зохион байгуулж, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд санал шүүмжлэл сонссон. Түүнчлэн Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Ардчилсан сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн *International institute for democracy electoral assistance IDA*-ийн шинжээчдээс, мөн ХБНГУ-ын Холбооны үндсэн хуулийн шүүхийн шүүгч асан, профессор, доктор Михаел Айхбергерээс саналыг нь авч, өгсөн холбогдох саналыг Монгол Улсын онцлогт тохирох эсэхийг нь нарийн шүүж, хэрэгцээтэй гэсэн саналуудыг хуулийн төсөлд тусгасан.

ҮХЦ-ийн тухай хуульд оруулсан зарчмын өөрчлөлтүүдийн талаар та бүхэнд товч танилцуулъя. 1.Цэцийн гишүүнд тавих болзол шаардлагыг тодорхой болголоо. Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих шүүх юм. Тийм учраас гишүүн нь шүүгчээр ажиллах наад захын шаардлага хангасан байх ёстой гэж Ажлын хэсэг үзсэн. Үндсэн хуулийн маргаан бол хууль зүйн маргааны нэг төрөл бөгөөд түүнийг зөв шийдвэрлэхийн тулд хууль зүйн мэдлэг ур чадвараас гадна Үндсэн хуулийн онол философийн мэдлэг хэрэгтэй учраас Цэцийн гишүүн эрх зүйч байх ёстой гэж үзсэн. Эрх зүйч байх нь зохистой гэж үзсэн. Хууль зүйн өндөр мэргэшил гэдэг бол хуульч, эрх зүйч байгаад зогсохгүй тухайн мэргэжлээрээ тодорхой хугацаанд ажиллаж туршилага хуримтлуулсан байх явдал юм. Түүнчлэн аливаа улс төрөөс ангид байлгах ёс зүйн

шалгуур тавьж Цэцийн гишүүнээр сүүлийн 4 жилийн хугацаанд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхлээгүй, санаатай гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй гэсэн шаардлагыг тусгайлан оруулсан. Энэ нь манай улсын ердийн шүүх, Шүүхийн сахилгын хороонд хэрэгждэг бас сайн туршилага юм.

2.Цэцийн гишүүнийг зөвхөн нэг удаа дахин томилж болгохоор тусгалаа. Цэцийн гишүүний дахин томилгоог хязгаарлаагүй тохиолдолд Цэцийн гишүүн дахин нэр дэвших, томилогдохын тулд санал болгох, томилох эрх бүхий этгээдэд таалагдах сэдлээр ажиллах эрсдэлтэй байна гэж үзэж байгаа юм. Энэ нь Цэц Үндсэн хуулийг хэрэглэж, маргаан хянан шийдвэрлэдэг болохынхоо хувьд гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлээс бүрэн хараат бус байх зарчим зөрчигдөх нөхцөлийг бий болгодог. Хэдийгээр уг үндэслэлээр дахин томилох боломжийг хязгаарлах шаардлагатай гэж үздэг боловч ийнхүү дахин томилохыг бүрэн иүүд хязгаарлах нь Цэцийн гишүүний бүрэн эрхийг 6 жил байхаар Үндсэн хуульд заасан хүн ам цөөтэй манай улсад Цэц тогтвортой ажиллах, шийдвэрийн үндэслэлийг сайжруулахад бэрхшээл үүсгэж чадварлаг мэргэжилтнийг хангалттай хугацаанд ажиллуулж чадахгүй байх эрсдэлтэй. Венецийн Комиссын зүгээс Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг нэг удаа урт хугацаагаар томилох эсхүл зөвхөн нэг удаа дахин томилох боломжтой байх нь зүйтэй гэсэн зөвлөгөөг бас өгдөг. Үүний дагуу Цэцийн гишүүний хараат бус, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хуулийн төсөлд Цэцийн гишүүнээр зөвхөн нэг удаа дахин томилж болно гэсэн олон улсын сайн туршилагыг тусгалаа.

3.Цэцийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох хугацааг тусгайлан зохицууллаа. Цэцийн гишүүнийг нэр дэвшүүлэх томилох хугацааг бүрэн гүйцэт зохицуулаагүйгээс Цэцийн гишүүнээр ажиллах хугацаа нь заасан

хугацаа дууссан атал эрх бүхий байгууллага албан тушаалтан Цэцийн гишүүнд нэр дэвшүүлэхгүй удах энэ нь 1, 2 жил хүртэл үргэлжлэх гэх мэт эрх зүйн хийдлийг бий болгосон асуудал өнгөрсөн хугацаанд багагүй гарсан. Иймд хуулийн төсөлд Цэцийн гишүүнийг нэр дэвшүүлэх томилох хугацааг нарийвчилж зохицууллаа. Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө эсвэл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсон өдрөөс хойш 45-аас дээшгүй хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтан Цэцийн гишүүнд тавих болзол шаардлагыг хангасан иргэнийг нэр дэвшүүлж, саналаа Улсын Их Хуралд хүргүүлэхээр заалаа.

4.Цэцийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох журмыг тодорхой тогтоож өглөө. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд Цэцийн гишүүнд нэр дэвшигчийг сонгох томилох процессыг тусгайлан зохицуулаагүй нь улс төрийн зүй бус нөлөө, эрх бүхий этгээд дур зоргоор халдах нөхцөлийг бий болгосон сул талтай байна гэж судлаачид үзсэн. Иймд хуулийн төсөлд Улсын дээд шүүх болон Ерөнхийлөгч цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх процессыг өөрсдийн журмаар нарийвчлан зохицуулахаар тусгаж, Улсын Их Хурлын хувьд олонх, цөөнхийн оролцоог хангасан хэлбэрээр тусгайлан зохицууллаа. Тодруулбал Үндсэн хуулийн шүүхийн гишүүнийг парламентаас сонгож байгаа тохиолдолд нэг талын сонголт биш, улс төрийн үзэл бодлын өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц байх баталгааг хангах ёстой. Ингэхдээ Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийг тэнцвэртэйгээр, хэрэв аль ч нам эвсэл олонх болоогүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам эвслийн авсан суудлын тоогоор нь хувь тэнцүүлэн байгуулж байгуулсан 9 гишүүн бүхий ажлын хэсэг байгуулж, ажлын хэсэг нэр дэвшигчийг нийт гишүүнийхээ 2/3-ын саналаар сонгох, нэр дэвшигчийн танилцуулгыг олон нийтэд нээлттэй зарлах зэргээр тусгасан нь Улсын Их Хурлын гишүүдийн олонх, цөөнхөд хүлээн

зөвшөөрөгдсөн нэр дэвшигч сонгогдох нөхцөл бүрдэх юм.

Түүнчлэн Улсын Дээд шүүхээс санал болгож томилох нэр дэвшигч нь хяналтын шатны шүүгч байхаар тусгасан нь Цэцийн процессыг Үндсэн хуулийн шүүхийн жишигээр хөгжүүлэх, шийдвэрийн чанар үндэслэлийг сайжруулахад чухал алхам болно гэж үзэж байна. Хуулийн төсөлд Улсын Их Хурал, Улсын дээд шүүх болон Ерөнхийлөгч Цэцийн гишүүнд тавих болзол шаардлагыг хангах боломжтой хүмүүсийг судлах, ярилцлага хийх, ил тод байх, олон нийтийн болон мэргэжлийн байгууллагын оролцоог хангах зэрэг асуудлыг зохицуулсан журмыг тус бүрдээ баталж, цахим хуудастаа байршуулахаар дагалдан өргөн барьсан хуулиудад тусгалаа.

5.Цэцийн гишүүнд нэр дэвшигчийг нэр дэвшигчийн танилцуулгыг олон нийтэд нээлттэй мэдээлэхээр зохицууллаа. Венецийн комиссоос нэр дэвшигчдийн жагсаалтыг санал оруулагч нар өөрсдийн цахим хуудсаараа нийтэлж, 10 хоногоос доошгүй хугацаанд олон нийтэд нээлттэй байлгах хэрэгтэй гэж зөвлөдөг. Иймд нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгохоосоо өмнө танилцуулгыг нь 5-аас доошгүй ажлын өдөр цахим хуудсандаа байршуулж, олон нийтэд мэдээлэх, саналыг нь авахаар зохицууллаа. Ийнхүү Цэцийн гишүүнийг нэр дэвшүүлэх томилох хугацааг ойлгомжтой болгож, зүй бус нөлөөллөөс хамгаалах олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

6.Цэцийн нийт гишүүний хуралдааныг байгуулж холбогдох бүрэн эрхийг олголоо. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд маргаан хянан шийдвэрлэхээс бусад асуудлыг Цэц хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалт дутмаг учраас тодорхойгүй байдал ихээхэн үүсдэг юм. Түүнчлэн Цэцийн даргад хэт олон асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхийг төвлөрүүлж, тогтоол,

тушаал гаргах зохицуулалт одоо үйлчилж байна. Өнгөрсөн хугацаанд гарсан зөрчил хийдлийг засах зорилгоор ҮХЦ-д нийт гишүүний хуралдаан ажиллахаар зааж, энэ нь маргаан хянан шийдвэрлэхээс бусад асуудлыг шийдвэрлэхээр тусгалаа.

7.Цэцийн чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүтэц хүний нөөцийг бүрдүүлэхийг зорьж байна. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд Цэцийн гишүүн, түүнд туслах судлаач, мэргэжил арга зүйн тусалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтнуудын эрх зүйн байдлыг тодорхойлоогүй орхисон байдаг юм. Цэц үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхээр хуулийн төсөлд заасан бөгөөд ийнхүү Цэцэд хандах хүрээ нэмэгдэхтэй уялдуулан Цэцийн маргаан хянан шийдвэрлэх бүтэц хүний нөөцийг бэхжүүлэх хэрэгцээ шаардлага үүснэ гэж үзлээ. Иймд Улсын дээд шүүхийн шүүгчийн нэгэн адил Цэцийн гишүүн нэг туслах, нэг судлаачтай байхаар хуулийн төсөлд тусгалаа. Түүнчлэн Цэц судалгааны төв, номын сантай байхаар зохицуулсан нь Цэцийн шийдвэрийн чанар, үндэслэл, судалгааг сайжруулахад чиглэсэн шинэчлэл болно.

8.Цэцийн гишүүний хараат бус байдлыг хамгаалах талаар. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгаагаар Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа хэт ерөнхий байдлаар зохицуулсан нь Цэцийн гишүүний хараат бус байдалд халдах эрсдэлийг бий болгож байгааг тэмдэглэжээ. Бусад улсын жишгийг харахад Цэцийн гишүүдийн эдийн засгийн баталгаа, эрх зүйн байдлыг тусгайлан тодорхой зохицуулах замаар хараат бус байдлыг нь бэхжүүлдэг байна. Иймд Цэцийн хараат бус байдлыг хангахын тулд гадаад улсын сайн жишгийг судлан, Цэцийн гишүүний баталгаа, эрх зүйн байдлыг нарийвчлан зохицууллаа. Цэцийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлөхийг оролдсон үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Цэцийн гишүүн

маргаан хянан шийдвэрлэх явцад бусад этгээдээс үзүүлэх аливаа нөлөөллийг хориглох, ийм үйлдэл, эс үйлдэхүйг баталгаажуулж, хариуцлага тооцох нөлөөллийн мэдүүлэг хөтлөх тогтолцоог тусгалаа.

9.Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах үндэслэл, журмыг нарийвчлан тусгалаа. Цэцийн гишүүний халдашгүй байдлыг хуулиар тогтоох, Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулах, чөлөөлөх, тэтгэвэрт гарах зэрэг нөхцөлийг аливаа дур зоргоос хамгаалах механизмыг хуульчилсан байх. Иргэний эрхээ хязгаарлуулсан байдалтай нь дүйцэхүйц байдлаар амьдралын баталгааг бүрдүүлэх нь хараат бус байдлын баталгаа болдог юм, болдог билээ. Иймд Цэцийн дарга, гишүүнд холбогдуулан үүсгэсэн гэмт хэргийг мөрдөн шалгах явцад уг гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх шаардлагатай гэж үзвэл энэ тухай саналаа УЕП Цэцэд хүргүүлэх бөгөөд асуудлыг Цэцийн нийт гишүүний 2/3-ын саналаар шийдвэрлэдэг байхаар төсөлд тусгалаа.

10.Эрхээ сэргээлгэх хуульд заасан арга замыг дуусгасны дараа уул эрх нь зөрчигдсөн хэвээр гэж үзсэн иргэн Цэцэд өргөдөл гаргах эрхийг нэмж тусгалаа. Иргэн өөрийн эрх ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл Цэцэд өргөдөл гаргах эрхтэй байгаа нь Цэц үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэх агуулгатай бөгөөд Үндсэн хуулийн анхны үзэл баримтлал нь үүнд чиглэсэн байна гэж ажлын хэсэг үзсэн. Түүнчлэн Цэц зөвхөн хийсвэр хяналтыг хэрэгжүүлэхээр нөхцөл байдлыг бий болж улмаар Цэцийн шийдвэрийн үндэслэл чанарт сөргөөр нөлөөлж байна. Иргэдийн үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхгүйгээс манай улсад үндсэн эрх зөрчигдөж, эдгээр зөрчил Үндсэн хууль хуулийн Үндсэн хуулийг хэрэглэж шийдвэрлэгдэж чаддаггүй, ердийн шүүх нь зөвхөн Үндсэн хуулиас бусад хууль хэрэглэж маргааныг шийдвэрлэдэг тул үндсэн эрхийн зөрчлийг Үндсэн хуулийн түвшинд

хамгаалах боломжгүй байдагтай холбоотой гэж үзэн ҮХЦ үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэх шинэ зохицуулалтыг тусгалаа.

Цэцийг үндсэн эрхийн маргаан хянан шийдвэрлэхээр зохицуулж буйтай уялдуулан үндсэн эрх гэдэгт ямар эрхийг хамааруулах талаар эргэлзээ үүсэхээс сэргийлж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрхүүдээс иргэний болон улс төрийн эрх, сурч боловсрох эрхийг үндсэн эрхийн түвшинд хамгаалахаар тусгалаа. Ингэхдээ иргэн хуульд заасан арга замыг дуусгасны дараа ч үндсэн эрх нь зөрчигдсөн хэвээр гэж үзвэл Цэцэд өргөдөл гаргаж хянан шийдвэрлүүлэхээр зарчмын шинэжтэй өөрчлөлт тусгалаа.

Нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд ҮХЦ нь Улсын дээд шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох бус хэрэв Үндсэн хуулийн зөрчил гарсан байна гэж шийдвэрлэсэн тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Улсын дээд шүүхэд шилжүүлэх бөгөөд шүүхийн шийдвэрийг хүчингүй болгохгүй юм. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ц.Мөнхцэцэг: Мөнх-Оргил гишүүнд баярлалаа. ҮХЦ-ийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Байнгын хорооны гишүүдээс асуулт асуух гишүүдийн нэрс авъя. Мөн би бас асуулттай байгаа. Ингээд Ганбат гишүүн та асуултаа тавина уу.

Д.Ганбат: Энэ Цэцийн тухай хуулийг шинэчилсэн найруулгыг ингээд боловсруулаад оруулж иржээ. Энэ маань тэгээд яг өнөөдрийн хоолойд тулсан асуудал мөн үү? Тэгээд өнөөдрийн ХЗБХ-ны хурал 12 хүний ирцтэй гэж байгаа боловч энэ танхимд бол 4, 5-хан л хүн сууж байна шүү дээ. Ийм байдлаар бид нар энэ асуудлыг ингээж хэлэлцэж ярилцах нь ямар вэ? Тэгээд гадаа өвөлжилт хүндэрчихсэн, хаваржилт хүндэрчихсэн, цас зудтай ийм хэдий хүнд хэцүү байхад нэг байгууллагын нэг албан тушаалтны хууль яриад байхад бол ёс

суртахуунд нийцэх юм уу? Ёс зүйтэй юу энэ?

Нөгөө талаар энэ 8 жилийн хугацаанд ер нь сүүлийн 30-аад жил ҮХЦ-ээрээ янз янзаар хуулийг нь оролдож иржээ. 10 хэд гэххэв үү нэг тоо хэлээд байх шиг байна. Тэгээд ҮХЦ дээр аваачиж янз бүрийн шийдвэр гаргадаг. ҮХЦ бол тоглоомын байгууллага болсон гэдэгтэй санал нэг байна. Өнөөдрийн хууль тогтоож байгаа 76 гишүүн бол 2020 оны сонгууль 40 хувийн санал ард нийтийн 40 хувийн саналаар л сонгогдчихсон ийм л олонх эрх барьж байгаа. Энийг энэ алдааг бид нар Үндсэн хуульдаа оруулж засаад, нийт ард түмний санал тусгагдсан ийм парламенттай больё гээд 126 хүний тоотой тогтолцоог нь өөрчлөөд ингээд оруулчихсан. Ингээд олон намууд хүнийг дэвшүүлнэ. Манай намын бүлэг хуралдсан нэг дэх өдөр. Энэ хуулийн тухай авч хэлэлцсэн. Энэ удаа бол энэ парламентаар ийм хүнд хэцүү үед ийм асуудлыг хэлэлцээд яриад ингээд байж байх нь бол ёс суртахуунгүй гэдгийг манай бүлгийн гишүүд 100 хувийн саналаар бол шийдвэрлэчихсэн. Тэгээд ганц танай бүлэг ярилцаад ингээд энэ хуулийг ингээд цааш нь ингээд шийдвэрлээд ингээд явах нь бол ийм хүнд хэцүү үед бол нийцэхгүй.

Тэгээд ч дараа нь удахгүй сонгууль болох гэж байна. Сонгуулийн дараа бол энэ хууль тогтоогчдын тоо ч арай өөр болно. Ард түмний санал ч гэсэн энэ Улсын Их Хуралд зөв тусгагдана. Тэгээд ҮХЦ-ийн талаар яриад байвал зөндөө л асуудал байна. Энэ асуудалтай холбогдоод ч юм уу сүүлийн үед тэр ҮХЦ-ийн гишүүдийн байгаа байдал дээрх бичлэг энэ юм хум бол үнэхээр олон түмний сэтгэлийг түгшээхүйцээр явж байгаа. Цэцийн дээр хөх тэнгэр байна энэ тэр гээд бид нар ярьдаг. Хуучин бол үнэхээр сайхан улсууд тэр ҮХЦ-д ажилладаг байлаа л даа, шилдэг хуульчид. Манай Амарсайхан доктор энэ тэр гээд л ийм хүмүүс байдаг байсан. Одоо бол тийм биш болсон. Тэр Монгол

Улсын хөгжилд хэрэг болохуйц шийдвэрийг тэнд хэн нь байхгүй болгоод байгаа нь мэдэгдэхгүйгээр ингэж шийдвэрийг өөрчилдөг. Тэгээд тэр Цэцэд ажиллаж байсан хүмүүсээ бол дараа нь ямар нэгэн хариуцлага хүлээлгэхгүйгээр ах дүү амраг садныг нь бол албан тушаалд тавьдаг. Энийг нэг их нууц биш. Энийг бүгд л мэдэж байгаа.

Тэгээд энэ олон түмнээр хэлэлцүүлсэн ч юм байхгүй байна гэж бодоод байна би бол. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу бол олон түмнээр хэлэлцүүлж ярилцуулж энэ талаар санал бодлыг нь авсан байх хэрэгтэй. Нэг хэдхэн хүмүүсийн хооронд ярилцаад л энэ хуулийг ингэж баталдаг барьдаг байх нь хэр зүй зохистой юм бэ? Энэ бол одоо бас хууль санаачлагч нь энийгээ татаад авчхаач. Тэгээд Улсын Их Хурлыг ингэж муухай харагдуулах, ХЗБХ-г ингэж муухай.../минут дуусав/

П.Цогтбаатар: Хууль санаачлагч хариулъя.

Ц.Мөнх-Оргил: 1 дүгээрт Ганбат гишүүнээ энэ хувь хүний ч юм уу, байгууллагын хэдэн албан тушаалтнуудын тухай хууль биш шүү. Энэ бол Үндсэн хуулийг хамгаалах асуудал, Үндсэн хуулийг чандлан биелүүлэх асуудал, Монгол Улсын иргэн Үндсэн хуулиар олгогдсон үндсэн эрхээ хамгаалуулах баталгааны асуудал шүү. Хэдэн хүнийг тэнд томилчихоод л орхичих гээд байгаа тухай асуудал энд огт биш шүү.

2 дугаарт энэ хуулийн төслийг боловсруулах ажил 3 жил гаруй хийгдэж байна, 3 жил гаруй. Би түрүүн танилцуулгадаа уншсан хэд хэдэн том, том хэлэлцүүлэг хийсэн талаар хэллээ. Том ажлын дэд хэсэг гарч ажилласан танилцуулсан. Тэр судалгаануудаар интернэт дээр манай цахим парламент дээр жил хагас гаруй энэ хуулийн төслийг тавьж хэлэлцүүлж ийм саналууд ирсэн, Ганбат гишүүнээ одоо та энийг харчих. Энэ ийм саналууд ирсэн. АН-ын зүгээс энэ

асуудалд ач холбогдол өгч Гончигдорж Их Хурлын гишүүн асан, Тэмүүжин гишүүн Их Хурлын гишүүн асан нар энэ хуулийн төсөл дээр саналаа өгсөн. Энэ хүмүүсийн санал нэлээдгүй туссан. Тэгээд энэ 20 гаруй жил яригдаж маргалдаж эцсийн дүнд нь хууль тогтоогчид хууль санаачлагчид бидний зүгээс улс төрийн зориг гаргаж үндсэн эрхийн маргааныг ҮХЦ-ээр хэлэлцүүлдэг болгох ийм эрх зүйн том шинэчлэлийн алхам хийж байхад АН энийг дэмжихгүй байгаад би маш их харамсаж байгаа. Энэ бол АН энэ асуудлыг олон жил ярьж ирсэн. Олон хүн энэ саналыг дэмждэг. Энэ заалт хууль болж ороод хэрэгжээд явах юм бол мэдээж эхлээд хүндрэл гарна. Нэг хэдэн жил бол хөл гараа олохгүй наана цаанатай болох байх.

Гэхдээ төлөвшсөний дараа бол Үндсэн хуульд заасан Монгол хүний эрх баталгаажих, баталгаатай хэрэгжих шүүхийн реформ дорвитой явахад энэ бол том хувь нэмэр болно. Тэгээд ийм реформын алхмыг манай АН-ын бүлэг дэмжихгүй байгаад би харамсаж байна. Энэ нөгөө гол проблем нь юу л юм шиг байна лээ л дээ. Нөгөө өргөн барьсан хуулийн төсөл биш, өргөн бариагүй өмнө нь хэлэлцэж байсан хэлэлцүүлгийн шатад байсан төсөл дээр АН-ын нөхдүүд саналаа өгчихсөн юм шиг байна лээ. Өргөн барьсан хуулийн төсөл дээр нь бол Гончигдорж, Тэмүүжин нарын яриад байсан, хэлээд байсан саналууд бол үндсэндээ тусгагдчихсан. Олон зөв зүйтэй саналууд хэлсэн. Тэр саналууд нь тусгагдсан.

Д.Цогтбаатар: Мөнхцэцэг гишүүн асууя. Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр ҮХЦ-ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ төслийг бол концепцийн хувьд дэмжиж байна. Ялангуяа хүний эрхийн асуудлаар Үндсэн хуульд хяналт хийх, Үндсэн хууль дахь ардчилсан ёсыг хангах, Монгол Улсын Үндсэн хуультай ёсны баталгааг бэхжүүлэх гол үүрэгтэй

субъект болох энэ ҮХЦ-ийг бэхжүүлэх нь ерөөсөө улс төрийн нам харгалзахгүйгээр Монгол Улсын ардчиллын тэгээд хүний эрхийг хангах энэ тогтолцооны чинь асар том механизм юм. Тийм учраас бид нар энийг бол яаралтай шийдвэрлэх, тэр дотроо ҮХЦ маань улс төрийн болон бусад зүйлээс хараат бусаар ажиллаж маргааныг шийдвэрлэх процессыг илүү нээлттэй олон улсын жишиг рүү нийцүүлэх энэ бол үнэхээр чухлаар тавигдаж байна.

Тэгээд дээрээс нь энэ ҮХЦ гэдэг болбол хуучны бид нарын 30 жилийн практикаас харахад зарим тохиолдолд тодорхой улс төрчдийн нөлөө бүхий этгээдүүд эсвэл улс төрийн нам болон тодорхой бүлэглэлийн төлөөлөл байсан гэдгээрээ бас иргэдийн дунд их шүүмжлэл хүлээж байсан. Тийм учраас бид нар энэ ҮХЦ-ийг илүү олон улсын жишигээр мэргэисэн Үндсэн хуулийн шүүх гэдэг рүү нь өөрчлөх нь асар чухал байгаа. Тийм учраас энэ асуудлыг бид нар дэмжих нь зүйтэй. Тэгээд тэр дотроо ялангуяа Улсын Их Хурал дахь Хүний эрхийн дэд хорооны даргын хувьд хүний үндсэн эрхийн зөрчил гомдлыг ҮХЦ хүлээн авч шийдвэрлэх, иргэн хүний мэдээлэл байна уу, өргөдөл байна уу энэ мөрөөр ажиллах нь бол үнэхээр чухал зүйл. Тийм учраас бид нар бол дэмжиж байна.

Тэгээд хууль төсөл өргөн баригчаас 2 асуулт байгаа. Ер нь манай энэ судлаачид эрдэмтэд Үндсэн хуулийн шүүхийн мэргэжилтнүүд бол энэ манай ҮХЦ-ийн гол энэ бүтэц зохион байгуулалт нь хэр мэргэисэн байх юм, яаж улс төрөөс хараат бус байх вэ энэ тал дээр нэлээн бас судалгаа зөвлөмжүүд өгч ирсэн. Мөн тодорхой асуудлаар иргэдийн өгсөн өргөдөл, хүсэлт, мэдээллийг ҮХЦ-ийн хуралдаанууд дунд суудлын болон их суудлын хуралдаан дээр төдийлөн ач холбогдол өгч ялгамжтай хандаж ирээгүй нэлээн тийм зөрчлүүд байсан. Тийм учраас ийм 2 асуулт байгаа юм. Энэ төсөл дээр энэ иргэний Цэцэд хандаж

өргөдөл мэдээлэл гаргах, хүсэлт гаргах энэ процессыг ялгамжтай байдлаар зохицууллаа гэж. Энэ дээр яг ямар ялгамжтай байдал оруулж байгаа вэ?

2 дугаар асуулт нь энэ Үндсэн хуулийн 65.2 дээр ҮХЦ-ийн гишүүн болбол хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй Монгол Улсын 40 нас хүрсэн иргэнийг томилно гэдэг Үндсэн хуулийн заалт байгаа. Төсөл дээр болохоор энэ хууль зүйн дээд боловсролтой ҮХЦ-ийн гишүүн байна гэж оруулж ирсэн байгаа. Тэгэхээр энэ яг энэ заалт маань яах вэ ерөнхийдөө нөгөө үндсэн хуулийн шүүх гэдэг рүү ойртуулаад заавал хуульчид ҮХЦ-д байна гэдэг энэ агуулгаар орж ирж байна уу? Олон улсын байгууллагууд Европын холбоо Венецийн комиссын зөвлөмжүүдээр болбол Үндсэн хуулийн шүүх болбол яг тодорхой нэг мэргэжлээр явцуурсан гэдэг юм уу аль нэг мэргэжлийг түлхүүд үзсэн байх нь бас Үндсэн хуулийн шүүхийн нөгөө олон талт байдлыг чинь алдагдуулна. Тийм учраас тодорхой нэг мэргэжлийн гэдэг юм уу хязгаарласан ийм байх нь бас зохимжгүй гэсэн ийм дүгнэлтүүдийг бас өгдөг.

Ер нь бол энэ нийгмийн олон талт байдал, олон янзын асуудал Үндсэн хууль руу хандах улс төр, эдийн засаг, соёл, шашин, хүний эрхийн зэрэг асуудлын улмаас ер нь Үндсэн хуулийн шүүгч өөрөө олон талт байдлыг төлөөлсөн байх нь зүйтэй гэдэг бас ийм зөвлөмжүүд олон улсын Венецийн комиссын болон бусад юунууд дээр байгаа. Тийм учраас яг энэ зөвхөн хууль зүйн дээд боловсролтой байна гэдэг бол тэр 65.2-ыг зөрчихөөс гадна аль нэг мэргэжлээр явцууруулсан юм болох вий гэдэг ийм болгоомжлол байгаа. Тэгэхээр энэ 2 асуулт дээр хариулт авъя.

Д.Цогтбаатар: Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Ер нь олон улсын жишигт энэ Үндсэн хуулийн хяналт тавьдаг байгууллага нь эсвэл шүүх байдаг, эсвэл консул буюу зөвлөх

байгууллага л байдаг л даа тийм ээ. Тэгээд манайх бол энэ асуудал бол нэг тийшээ маргаан дагуулж байгаад ер нь бол сүүлийн 30 жилийнхээ практикаар манай Цэц бол Цэц нэртэй боловч шүүх юм гэдэг дээр бол бид нар тохирчихсон шүү дээ. Нэгэнт шүүх юм бол эрх зүйн боловсролтой байхыг л шаардаж байгаа юм. Хууль зүйн боловсролтой байхыг л шаардаж байгаа. Тэр заавал өөр зөвхөн хуульчаараа ажилласан бай гэдэг шаардлага бас тавихгүй байгаа байхгүй юу. Эрх зүйн боловсролтой тэгэхдээ эдийн засагчаар ажиллаж байсан байж болно эсвэл Их Хурлын гишүүнээр ажиллаж байсан байж болно. Өөр ажил хийж байсан байж болно. Гэхдээ энд үндсэн эрхийн маргаан орж ирээд нөгөө шүүхийн байгууллага болж байгаа учраас тэр хүн Цэцийн гишүүн болчихоод хүний хувь заяаны үндсэн эрхийн асуудал шийдэх гэж байхад нь тэр хүнд дахиад эрх зүйн боловсрол олгоод сууж байх нь зохимжгүй юм. Тийм наад захын шаардлага хангасан байх ёстой л гэж үзэж байгаа юм. Тэгээд энэ бол хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй гэдэг шаардлага нь бол хэвээрээ.

Энэ хараат бус байх баталгааг яаж хангах вэ гэдэг дээр үндсэн гол нэг ийм асуудал байгаа юм. Манай Үндсэн хуульд 6 жилээр томилно гэххээд дахиж томилж болох юм уу, болохгүй юу гэдэг заалт ерөөсөө хоосон орхигдчихсон. Тэгэхээр олон улсад бол ямар практик, ер нь бид нар дотоодынхоо амьдрал дээр ч гэсэн юу хараад байна вэ гэхээр эсвэл насаар нь томилж байна манай Дээд шүүхийн шүүгч нар шиг, манай шүүхийн шүүгч нар шиг эсвэл нэг удаа 9 жилээр томилж байна Солонгосууд. Манайх шиг 4 жилээр томилчихоод тэгээд хэдэн ч удаа дахин, дахин томилоод байдаг тийм тогтолцоо байхгүй. Энэ өөрөө их аюултай байгаа байхгүй юу. Би нэг хүнээс томилолт аваад тэр хүн намайг Улсын Их Хуралд нэр дэвшүүлээд Цэцийн гишүүнээр томилчихсон байх юм бол би 4 жилийн дараа дахиад нөгөө хүнээсээ эрх авч нэр дэвшихийн төлөө л явахаас өөр аргагүй байдалд бид нар тулгаад байгаа

байхгүй юу. Энэ бол манай 30 жилийн практикт бол нэлээн харагдсан, ажиглагдсан шүү дээ. Тэгэхээр одоо бол бид нар Үндсэн хуульдаа нэгэнт 1 удаа гэж заагаагүй олон удаа томилж болно гэж заагаагүй байгаа учраас хууль тогтоогч 4 жилээр томилъё. Тэгээд 1 удаа улируулан томилъё гэдэг саналыг оруулж байгаа юм.

Тэр өргөдөл мэдээлэл хүсэлт гэдгийг ялгаж өгсөн үү, ялгаж өглөө гэж байгаа юм. Энэ их ач холбогдолтой чухал асуудал Мөнхцэцэг гишүүн асууж байгаа юм. Өргөдөл гэдэг бол үндсэн эрхийн маргааны асуудал өргөдөл. Яг өөртэй нь хамаатай асуудал. Жишээ нь иргэн Мөнх-Оргилын эрх чөлөөгөө эвлэлдэн нэгдэх эрхийг боомилчихсон яг надтай хамаатай үндсэн эрх зөрчигдсэн асуудал гарах юм бол би бол өргөдөл гаргана.

Д.Цогтбаатар: Мөнх-Оргил гишүүний микрофоныг нэмээд өгье.

Ц.Мөнх-Оргил: Мэдээлэл гэдэг нь бол яг надад өөрт хамаагүй. Гэхдээ тухайн баталсан хууль тогтоомж, заавар, ЗГ-ын шийдвэр нь Үндсэн хуулийн аль нэг заалтыг зөрччихсөн байна гэж нөгөө хийсвэр хяналт тавиулах хүсэлт тавьж байгаа шүү дээ одоогийн абстрактаар юу яаж. Тэр өргөдлөө гарга тэрийг гаргах юм бол тэрийг мэдээлэл гэж тооцъё.

Хүсэлт гэдэг нь бол нөгөө Үндсэн хуульд заасан албан тушаалтнуудын Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, ЗГ, нөгөө Ерөнхий прокурор эд нар асуудал тавьдаг шүү дээ. Тэрийг бол хүсэлт гэж тодорхойлж байгаа. Ингээд 3 салгаж өгч байгаа юм.

Энэ шүүх болж байгаагийнх нь хувьд Дээд шүүхээс нэр дэвшигч нарыг Дээд шүүхийн шүүгч нар байя гэдэг шаардлага тавьж байгаа юм. Энийг Дээд шүүх бол хүлээн зөвшөөрч байгаа. Ер нь тэгэхээс ч өөр аргагүй гэдгийг дэмжиж байгаа. Энэ бол тэгэхдээ одоо Дээд шүүхээс томилогдож ажиллаж байгаа

хүмүүст хамаарахгүй. Шинээр Дээд шүүхээс томилогдож ажиллах хүмүүст хамаарна. Дээр нь энэ дээр энэ шүүх болж байгаатай холбогдуулж нэг хэлэх чухал зүйл бол энэ ялангуяа үндсэн эрхийн маргааны асуудал ороод ирэх юм бол эхний хэдэн жилдээ Цэц бол энэ үндсэн эрхийн маргаанд дарагдана. Эхний 1, 3, 4 жил бол ерөөсөө асуудал болгон тийшээ очно. Тэгэхээр энийг дунд нь шүүдэг шүүлтүүрүүд хэрэгтэй. Тусалдаг судлаачид, ялгаж салгаж өгдөг аппарат туслах мэргэжлийн зөвлөгөө өгдөг байгууллагууд хэрэгтэй. Энийг нь бол бид нар Цэцийн хуульд нь бас нарийвчлан тусгаж өгч байгаа.

Д.Цогтбаатар: Би нэг асуулт асуучихмаар байна. Нэг ийм юу байна. Энэ шинэ юу нэмэлт, өөрчлөлтийн төсөл дээр болохоор 6.7-д юу яасан байгаа юм. Энэ ҮХЦ-ийн гишүүнийг юу сонсгол зохион байгуулж томилно гээд. Тэгтэл өнөөдөр одоо ҮХЦ маань нөгөө юу 23 онд 9 сард байгаа байх энэ чинь дүгнэлт гаргаад энэ сонсгол явуулж байгаа нь Үндсэн хуулийг зөрччихсөн байна гэдэг дүгнэлт гарчихсан байгаад байгаа юм. Тэгэхээр одоо энэ хуулийг чинь бид нар ингээд батлахад байна шүү дээ ҮХЦ юу Үндсэн хууль зөрччихсөн байна гээд шийдвэр гаргачхаад их суудлаараа хэлэлцээгүй байгаа учраас өнөөдөр бол энэ хүчин төгөлдөр явж байгаа. Шууд гарснаасаа хойш хүчин төгөлдөр болчихсон. Тэгэхээр бид нар энэ заалт чинь өнөөдөр Үндсэн хуулиа одоо байгаа фактаараа зөрчөөд ороод ирчихсэн байгаа болчих гээд байх шиг байна л даа. Тэгээд бид нар энийг чинь баталчих юм бол Их Хурал мэдсээр байж Үндсэн хууль зөрчиж шийдвэр гаргаж байгаа юм шиг болох гээд байгаа. Энийг бодолцож үзсэн үү, энэ дээр чинь ямар хариулт байгаа вэ? Мөнх-Оргил сайдын микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: 1 дүгээрт Цэцийн дунд суудлын дүгнэлт гарсан. Улсын Их Хурал дунд суудлын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй гээд хариугаа өгчихсөн. Их суудал хуралдахаа хүлээж байгаа юм. Их

суудлын шийдвэр гараагүй тохиолдолд энэ хуулийн заалт хэвээрээ үйлчилж байгаа 1 дүгээрт.

2 дугаарт Цэц энэ дүгнэлт гаргахдаа нэлээн логиктой буюу нюанстай дүгнэлт гаргасан юм байна лээ. Улсын Их Хурал бүхэлдээ сонсгол хийж байгаа нь буруу гэж хэлээгүй байгаа байхгүй юу. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн нэр дэвшүүлж байгаа хүмүүс дээр сонсгол хийж байгаа, Дээд шүүхээс нэр дэвшүүлж байгаа хүмүүс дээр сонсгол хийж байгаа нь Ерөнхийлөгчийн болон Дээд шүүхийн бүрэн эрхэд халдаж байна гэсэн дүгнэлт хийсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр Улсын Их Хурал өөрөө нэр дэвшүүлж байгаа хүмүүс дээрээ сонсголоо хийх нь Улсын Их Хурлынх нь бүрэн эрхийн асуудал. Ерөнхийлөгч Дорж, Долгор зөв хүн байна гээд өөрөө тэнчээнээ сонгон шалгаруулалт хийгээд оруулаад ирэхээр нь тэрийг нь Улсын Их Хурал дахин сонсгол хийгээд байгаа нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд халдлаа гэдэг нюанстай дүгнэлт гаргасан байгаа байхгүй юу. Тэгэхээр тэрийг нь бид нар харгалзаж үзээд энэ хуульд ямар өөрчлөлт оруулж байгаа вэ гэхээр 1 дүгээрт Улсын Их Хурлын Дэгийн тухай хуульд Улсын Их Хурлаас нэр дэвшиж байгаа хүмүүс дээр сонсгол хийнэ. Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад Ерөнхийлөгч нэр дэвшүүлэхдээ өөрөө тэндээ сонсголоо зохион байгуулна дээ. Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулаад шүүх нэр дэвшүүлэхдээ өөрөө тэнчээнээ сонсголоо зохион байгуул гэдэг шаардлагыг тавьж байгаа юм.

Тэгэхээр нөгөө Цэцийн хэлээд байгаа бүрэн эрхэд нь халдлаа гэдэг нөгөө дүгнэлт байхгүй болчихож байгаа юм. Энэ дээр бол бид нар Дээд шүүх, Ерөнхийлөгчийн Тамгын газар эд нартай зөвлөлдөж санал авсан. Дээд шүүх ч гэсэн өөрөө бол маш нарийн журам баталчихсан юм байна лээ. Цэцэд нэр дэвшүүлэх хүмүүсийг яаж сонгож шалгаруулах вэ гээд. Тэрэн дээрээ бол

тэд нар сонсгол зохион байгуулна гэж нэмээд л, тэгээд л тэд нар бол асуудлаа шийдчихнэ. Ерөнхийлөгч бол бас өөрийнхөө зарлигаар баталсан журамтай юм байна лээ. Тэрэн дээрээ сонсгол зохион байгуулах асуудлаа шийдчихнэ. Тэгэхээр бол энэ сонсгол 3 нэр дэвшиж дэвшүүлдэг 3 байгууллага гурвуулаа тус тусдаа сонсголоо зохион байгуулаад явна. Ерөнхийлөгч сонсгол зохион байгуулаад, Дээд шүүх сонсгол зохион байгуулаад ороод ирсэн хүмүүс дээр Улсын Их Хурал дахиж сонсгол зохион байгуулахгүй, шууд дэмжинэ, дэмжихгүй гэдэг санал хураалт л явуулна.

Энэ дээр бас нэг нюанс нь бол одоо бид нар нөгөө нэг хүнийг нэг удаа л улируулан томилъё гэж байгаа шүү дээ тийм ээ. Тэгэхээр улируулан томилж байгаа тохиолдолд тэр хүн дээр дахин сонсгол явуулахгүй гэж байгаа юм. Тэгэхгүй бол нөгөө 4 жилийн хугацаанд гаргасан шийдвэр дээр нь хэлэлцүүлэг болчих гээд байх аюул байгаа учраас тэрэн дээр нь бол дахин сонсгол хийх шаардлагагүй гэж үзэж байгаа юм. Цэцийн шийдвэрийг бол бид нар хүлээгээд авчхаж байгаа байхгүй юу.

Д.Цогтбаатар: Тэгэхээр энэ дээр бол өөрөөр хэлбэл бид нар баталснаар одоо энэ чинь та бид 2-ын энэ ярьж юу яаж байгаа чинь энэ дараагийнхаа тайлбарт ороод явчихна шүү дээ. Энэ дээр бол зөрчил байхгүй. Зөвхөн одоо бид нар сонсгол явуулна гэж байгаа нь Их Хурлаас нэр дэвшүүлж байгаа хүн дээрээ сонсгол явуулна гэдэг. Тэгээд ҮХЦ-ээс гаргасан тэр дүгнэлттэйгээ зөрчилдөөгүй хэлбэрээр нь хууль орж ирлээ гэж ойлгож байгаа тийм ээ, окэй.

Ц.Мөнх-Оргил: Ерөнхийлөгч сонсгол явуулах асуудлыг Ерөнхийлөгчийнх нь хуулиар хийгээд авчхаж байгаа юм.

Д.Цогтбаатар: Тийм байна. Наадах чинь гэхдээ бас ер нь зүгээр хэлэлцүүлэг явуулбал хэцүү л юм байна.

Жишээлбэл Элчин сайд эд нарыг оруулж ирэхэд чинь Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн асуудал шүү дээ. Тэгээд Их Хурлаар хэлэлцээд байна шүү дээ. Яах вэ Их Хурлаар үгүй гэгчихсэн байхад ч гэсэн Ерөнхийлөгч томилоод явуулж болдгоороо харин засагдаж л байгаа юм байна. Тэгэхдээ ингээд хооронд нь уялдуулахлаар энэ чинь Их Хурал тэртээ тэргүй халддаг өөр томилгооны юмнууд бас байгаад байгаа. Тэрийгээ ҮХЦ маань авч хэлэлцсэн байна уу, үгүй юу? Мөнх-Оргил сайд. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Тэн дээр Элчин сайд нараас ялгаатай нэг юм байгаа юм. Цэцийн гишүүнээр томилох, эгүүлэн татах асуудал бол хамгийн эцэстээ очоод Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал байгаа байхгүй юу. Ерөнхийлөгч, Дээд шүүх 2 бол санал болгож л байгаа юм. Элчин сайд нарыг бол Ерөнхийлөгч томилно, зарлиг гаргаж томилно, Улсын Их Хуралтай зөвшилцөнө. Ийм ялгаатай учраас бид нар энийг нь бол өөрсдөө өөрийнхөө нэр дэвшүүлж байгаа хүмүүс дээр сонсгол хийнэ. Ерөнхийлөгчийг бол сонсголоо хийгээд нэрээ оруулж ир, таны сонсгол хийгээд оруулж ирж байгаа нэр дээр бид нар дахин сонсгол хийхгүй, дэмжих үү, дэмжихгүй юу гэдэг санал хураана л гэдэг асуудал явж байгаа. Ер нь бол сонсгол байх нь бол хэрэгтэй гэдэг дээр бол манай Их Хурлын гишүүд бол бүгд санал нэгтэй байгаа шүү дээ. Дээд шүүх ч оруулж ирж байна уу, Ерөнхийлөгч ч оруулж ирж байна уу, Улсын Их Хурал ч оруулж ирж байна уу хэнийг бид нар Дээд шүүхэд, Цэцэд илгээж байгаа юм бэ гэдгийг олон нийт мэддэг хардаг, ямар асуултад яаж хариулав гэдэг дээр харж байх тийм бололцоог нь бүрдүүлэх л асуудал. Мэдээллийн эрх чөлөөний л асуудал юм даа. Тийм.

Д.Цогтбаатар: Ойлголоо, тэгвэл ингээд юу асуулт асуух гишүүд асуултаа асууж, хариултаа авлаа. Одоо энэ асуудлаар үг хэлэх гишүүд байна уу?

Ганбат гишүүн. Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Энэ хууль ҮХЦ-ийн тухай хуулийг бол 10-аад хоногийн өмнө л өргөн барьсан шиг санагдаад байна. Тэгээд бид бүхний ингээд хоорондоо ярилцаж байгаа ирц уг нь 12 хүнтэй боловч энд 6, 7 л хүн сууж байна. Тэгээд бид нарын хоорондын хэлэлцээж байгаа, ярилцаж байгаагаас ингээд харахад бол үнэхээр бас дутуу дулимаг байна. Энэ хуулиар далимдуулаад цаад талд нь Цэц ч өөрөө тоглоомын байгууллага болчихсон байгаа л даа. Тэн дээр нь нэмээд улам бүүр тоглоомын байгууллага болгох бас нэг хэд хэдэн хүнийг хольж сольж тавих ийм л юм байгаа юм шиг байна.

Хууль санаачлагч түрүүн хариулж байна. Тэр тэрэнтэй ярьчихсан энэ тэр гэсэн юм ярина лээ. Тэр хүмүүс чинь тэгээд ард түмнийг төлөөлөхгүй шүү дээ. Тийм нэг ганц, хоёр хүнтэй ярьчихаараа тэгээд болдог юм шиг ингээд ийм ойлголт өгөөд байх юм. Энэ бол буруу шүү. Ийм маягаар хуулийг хэлэлцээж ингээж цаашаа явах ёсгүй. Тэгээд би хэд хэдэн удаа ёс суртахуунгүй гэдэг үгийг хэллээ шүү дээ. Энийг анхаарах хэрэгтэй.

Нөгөө талаар бол Цэц дээр бол янз янзын асуудлууд олон байна. Өмнөх Цэцийн явж ирсэн жишгийг ингээд харахад бол энэ хэн нэгэн хүн ямар нэгэн шийдвэр Монголын ард түмэнд хэрэгтэй, Монгол Улсыг хөгжүүлж байгаа ийм шийдвэрүүдийг Улсын Их Хурал олон түмний нүдэн дээр хэлэлцээд гаргадаг боловч тэрийг нь ямар нэгэн байдлаар тэнд өөрчилдөг, бараг хууль тогтоох шахуу эрхийг эдэлдэг. Ер нь Цэц чинь хууль тогтоогоод байгаа юм уу, шүүх болоод байгаа юм уу, энэ юм нь ойлгомжгүй болчихсон ийм байдаг. Мэдээж хэрэг энэ талыг бол сайн хэлэлцээж ярьж нэг мөр шийдэх нь бол зөв. Тэрэнтэй бол санал нийлж байгаа. Гэхдээ энэ хугацаа нь дуусаж байгаа энэ парламент энэ асуудлыг ингээд яаран

сандран хэлэлцээд, яаран сандран өргөн бариад, ингээд нэг хэдэн хүнийг тэнд яаралтай томилгоо хийгээд, тавиад, тэгээд дараа нь тэрүүгээрээ дамжуулаад ямар нэгэн байдлаар ял завиух ч юм уу, улс орны хөгжлийг боогдуулах ч юм уу иймэрхүү зүйлүүд ингээд гарч байсан, гарах гэж байна.

Тэгээд одоо бид нарын ярьж байгаа энэ хоорондын асуулт, хариулт ч гэсэн томилгоо нь ямар байх юм, яах юм хаанаасаа хэн нь очих юм гэсэн ийм л яриа болоод байна. Мэдээжийн хэрэг тэр сонсгол хийгээд хэлэлцээд тэр ард түмний мэдэх эрх шүү дээ. Энэ Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа, энэ ярьж байгаа юм чинь ард түмнийг төлөөлөөд хууль тогтоох гэж байгаа энэ байгууллага чинь тэр ямар хариуцлагатай, юу хийдэг, яадаг ийм хүн очиж байгаа юм бэ, тэрийг хэн нь санал болгоод байгаа юм энэ тэр гэдгийг мэдэх эрхтэй шүү дээ. Мэдэх эрхтэй байхгүй юу. Энэ ҮХЦ чинь эцсийн эцэст ард түмнийг хамгийн гол хамгаалдаг энэ зүйл бол Үндсэн хууль. Монголын ард түмэнтэй байгуулсан гэрээ бол Үндсэн хууль. Тэгээд энэ юмыг хүний эрхийг хэчнээн жил зөрчив бид нар. Үгээ хэлж чадахгүй, эвлэлдэн нэгдэж чадахгүй. Хүний эрхийн Комиссыг нь бид нар сайжруулаад л тавьсан барьсан гээд байгаа. Энэ 8 жилд энэ ард түмэн чинь эвлэлдэн нэгдээд үгээ хэлээд, үзэл бодлоо илэрхийлээд энэ юмыг нь хэвийн явуулж байсан бол хэчнээн зөв зүйтэй байх вэ. Хэчнээн энэ ард түмний амьдрал урагшлах вэ? Энүүгээрээ л ингээд л ухарч байгаа байхгүй юу.

Тэгээд нэг парламент нь парламентад байгаа гишүүдийн олонх нь 62, 65 суудалтай. Яг тэгээд санал аваад, ард түмний санал тусгагдахдаа бол 30, 40 хувийн саналыг авсан энэ нам эвсэл энэ хүмүүс 100 хувь энд шийдвэр гаргаад ингээд яваад байдаг. Энэ болохгүй байна гээд бид нар чинь Үндсэн хуулиа өөрчиллөө шүү дээ. Тэгээд тэр ард түмний санал тусгагдсан парламент нь хууль тогтоогчид нь орж ирээд энийгээ

ярья. Тэгэхгүй бол хөдөө гадаа гэхэд нэг хониор нэг боодол өвс сольж байна шүү дээ. 30, 40 мянга болчихсон тэр өвс нь. Тэр бол одоо малд бол тэжээл болж байна. Гэтэл Онцгой байдлын комисс тэр улсын татвар төлөгчдийн мөнгөөр авсан тэр өвс нь 16 мянгаар очоод, тэрийгээ 18-аар ингээд зарж байна. Одоо энэ шүүхээс гарч байгаа энэ шийдвэрүүд нь ял нь бол 40 саяар л торгож байна шүү дээ. 40 тэрбумыг, 44 их наядыг идчихсэн хүмүүст тэр юу юм бэ.

Д.Цогтбаатар: Сая энэ Ганбат гишүүний яриад байгаа юмнууд дээр гэхдээ анхаарах зүйл бий. Энэ Их Хурлын бас яг отгон чуулган болохоор бид нар аргагүй бодох ёстой, энэ ингээд олуулаа түрээд ялангуяа Үндсэн хуульд бид нар нэгэнт оролдож байгаа бол сөрөг хүчний ийм сэтгэхүйтэйгээр Үндсэн хуультай холбогдсон юмыг хамаагүй оролдоод байж болохгүй. Энэ бол зөв шүү. Тэр утгаараа Мөнх-Оргил гишүүнд би бүүр яг чиглэл өгмөөр байна. Байнгын хорооноос. Нэгэнт хууль санаачилж байгаа хүн учраас.

АН-ын бүлэг дээр та нэг ороод яг энэ, сая бол яах аргагүй завсарлаж барьчихсан байсан болохоор хэлэлцүүлэгт бүрэн гүйцэд оролцоогүй эсхүл оролцсон, оролцоод саналыг нь та тусгачихсан гээд тэгж байна шүү дээ. Саналыг нь тусгагдсанаа мэдээгүй бас явж байж болзошгүй шүү дээ. Тэгэхээр та бол бүүр тусгайлан орж, эдний бүлэгт танилцуулга хийгээд тийм, тэгээд энийгээ нэг талдаа гаргахгүй бол Үндсэн хууль бол бусад хуулиасаа нээрээ өөр болохоор энэ дээр бас энэ хэлж байгаа санааг нь бид нар анхаарах ёстой.

Ганбат гишүүнээ энэ нөхцөл байдал ийм хүнд байгаа үед ч гэсэн яг та сая өөрөө хэлчихлээ. Үндсэн хууль бол ард түмний чинь энэ засаглах эрхийг хамгаалж байгаа яг цорын ганц эцсийн тэр эрх мэдлийг баталгаажуулж байгаа харин хууль бол Үндсэн хууль байхгүй юу. Энэ төртэй яг нүүр тулаад зогсоход эзэн

нь би юм гэж төрийг байранд нь тавиулж байгаа хамгийн гол эх сурвалж бол Үндсэн хууль. Тэгэхээр таны сая яг та өөрөө ингээд ард түмнийг хамгаалж байгаа хууль чинь Үндсэн хууль гээд. Энэ дээр асуудал гарч байгаа бол хэдүүлээ ямар ч үед, ямар ч хүндрэлтэй үед хэлэлцээд бас шийдэж байхгүй бол, гацааг нь гаргаж байхгүй бол болохгүй учраас л энийгээ оруулж ирээд бас яриад хэлэлцээд явж байгаа шүү. Тэгэхдээ энэний ард тэр цаг хугацаа, мэдрэмж, ёс суртахууны асуудлууд чинь бас байгаа. Би тэрэн дээр бол санал нэгтэй байна. Ингээд гишүүд үг хэлж, санал, үг хэлж дууслаа.

Ингээд санал хураалт явуулъя. 54.5 хувиар энэ юу дэмжигдлээ. Өөрөөр хэлбэл юу энэ нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэх дээр хэлэлцье гэдэг томьёолоор гишүүд дэмжиж санал өглөө. 2 дугаар асуудал руугаа оръё. Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил нарын гишүүд 2024 оны 3 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь юу зүйтэй гэсэн энэ бол сая юугаа бид нар хураачихсан. Одоо энэ нөгөө ҮХЦ-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын юу, одоохон манай юу чинь.

11.55 цаг

Хоёр. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил нарын гишүүд 2024 оны 3 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн

мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг, асуудлын хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя. Төсөл санаачлагчтай, санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил танилцуулна. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

ХЗБХ-ны 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Монгол Улсын ҮХЦ-ийн тухай, ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахлан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг, Баатарбилэг, Батсуурь, Бямбацогт, Сандаг-Очир, Энхбаяр нар ажиллаж, хуулийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Монгол Улс 1992 онд нийгэм, улс төрийн шинэ тогтолцоонд шилжиж түүхэндээ анх удаа Монгол Улсын ҮХЦ нэртэй Үндсэн хуулийн шүүхтэй болсон бөгөөд Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийг 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр баталсан. Өнгөрсөн 32 жилийн хугацаанд Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаанд гарч буй өөрчлөлт, хөгжлийн хурдац, нийгмийн хэрэгцээг дагаж шүүх эрх мэдлийн бусад байгууллагын нэгэн адил Цэцийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг шинэчлэн боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна гэж ХЗБХ үзсэн учраас ажлын хэсэг байгуулсан билээ.

Ажлын хэсэг 30 гаруй жилийн алдаа оноог дүгнэн цэгнэж, дэлхий дахинаа төлөвшин хөгжиж буй Үндсэн хуультай ёс, Үндсэн хуулийн шүүхийн өсөн нэмэгдэж буй үүрэг хүний эрхийг тодорхой тохиолдолд хамгаалах

хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн өнгөрсөн 3 жилийн хугацаанд тасралтгүй ажиллаж хуулийн төслүүдийг боловсрууллаа. Ажлын хэсэг ҮХЦ, Улсын дээд шүүх, ХЗДХЯ, УЕП, Улсын Их Хурлын Тамгын газар, эрдэмтэн судлаачдыг оролцуулан ажлын дэд хэсгийг байгуулан мэргэжил арга зүй, зохион байгуулалтын туслалцаа авсан. Ажлын хэсгийн зүгээс Монгол Улсын ҮХЦ-ийн тухай болон ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд тулгамдаж буй асуудлыг тодруулж, эрдэмтэн судлаач, хуульч нартай зөвлөлдөж, хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор хэд хэдэн ажил зохион байгуулсан.

Тухайлбал Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг ХЗБХ, ХЗДХЯ, ҮХЦ, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнтэй хамтран зохион байгуулж, мөн ХЗБХ, ХЗДХЯ, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнтэй хамтран ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчлэл хэлэлцүүлгийг хуульчдын дунд зохион байгуулсан.

ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд тусгасан зарчмын өөрчлөлтийн талаар та бүхэнд товч танилцуулъя. 1.Цэц иргэний үндсэн эрх зөрчигдсөн тухай иргэний өргөдлийг хүлээн авч хянан шийдвэрлэхээр зохицууллаа. Иргэн өөрийн эрх, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл Цэцэд өргөдөл гаргах эрхтэй байгаа нь Цэц үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэх агуулгатай бөгөөд Үндсэн хуулийн анхны үзэл баримтлал нь үүнд чиглэсэн байна гэж ажлын хэсэг үзэж байгаа юм. Түүнчлэн Цэц зөвхөн хийсвэр хяналтыг хэрэгжүүлэх нөхцөл байдал бий болж, улмаар Цэцийн шийдвэрийн үндэслэл чанарт сөргөөр нөлөөлж байна. Иргэдийн үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхгүйгээс манай улсад үндсэн эрх зөрчигдөж, эдгээр зөрчил Үндсэн хуулийг хэрэглэж шийдвэрлэгдэж чаддаггүй. Ердийн шүүх нь Үндсэн

хуулиас бусад хуулийг хэрэглэж маргаан шийдвэрлэгддэг тул үндсэн эрхийн зөрчлийг Үндсэн хуулийн түвшинд хамгаалах боломжгүй байдагтай холбоотой гэж үзэн ҮХЦ үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэхээр тусгалаа.

Цэцийн үндсэн эрхийн маргаан хянан шийдвэрлэхээр зохицуулж буйтай уялдуулан үндсэн эрх гэдэгт ямар эрхийг хамааруулах талаар эргэлзээ үүсэхээс сэргийлж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний болон улс төрийн эрх, сурч боловсрох эрхийг үндсэн эрхийн түвшинд хамгаалахаар тусгалаа. Ингэхдээ иргэн хуульд заасан арга замыг дуусгасны дараа ч үндсэн эрх нь зөрчигдсөн хэвээр гэж үзвэл Цэцэд өргөдөл гаргаж, хянан шийдвэрлэхээр зарчмын шинжтэй өөрчлөлтийг орууллаа. Нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд ҮХЦ нь Улсын дээд шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох бус хэрэв Үндсэн хуулийн зөрчил гарсан байна гэж шийдвэрлэсэн тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Улсын дээд шүүхэд шилжүүлэх бөгөөд шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож байгаа зүйл огтхон биш юм.

2.Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хэлбэрийг ялган зохицууллаа. Дэлхийн олон улсад Үндсэн хуулийн шүүх нь шүүгчдээс бүрдсэн зөвлөлдөөнөөр маргааныг шийдвэрлэх эсхүл маргааныг амаар хэлэлцүүлэх нь маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой гэж үзвэл хуралдаан хийж, маргагч хариуцагч болон бусад оролцогчийг оролцуулан шийдвэрлэдэг журам үйлчилж байна. Манай улсын тухайд маргааныг заавал танхимд хэлэлцүүлсний үндсэн дээр шийдвэрлэх хуулийн зохицуулалт үйлчилж ирсэн. Хуулийн төсөлд зааснаар Цэц үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэдэг болсон тохиолдолд энэ зохицуулалт хэвээр үргэлжилбэл Цэцийн ачаалал ихсэх, чухал асуудалд төвлөрч чадахгүй маргааныг хугацаандаа шийдвэрлэх боломжгүй болох үр дагавар

үүснэ. Иймд хуулийн төсөлд Цэцийн хуралдааныг хуралдаан, зөвлөлдөөн гэж 2 хэлбэртэй байхаар зохицууллаа.

Тодруулбал хуралдаан гэж дунд, их суудлын хуралдаанаар үндсэн оролцогч, шаардлагатай тохиолдолд бусад оролцогчийг байлцуулан хуралдааны танхимд маргааныг амаар хэлэлцэхийг, харин зөвлөлдөөн гэж цугларсан нотлох баримтад үндэслэн маргааны оролцогчийг оролцуулахгүйгээр бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд маргааныг хэлэлцэж шийдвэрлэхээр ойлгохоор, шийдвэрлэхээр тусгалаа. Түүнчлэн Цэц маргааныг зөвлөлдөөнөөр шийдвэрлэх явцад үндсэн оролцогчийн тайлбарыг биечлэн сонсох, гэрч эсхүл бусад оролцогчийн мэдүүлэг, дүгнэлттэй амаар танилцах, тодруулга авах нь маргааныг бүрэн бодитой шийдвэрлэхэд нөлөөтэй гэж үзвэл бүрэлдэхүүн хуралдаан явуулах шийдвэр гаргаж болохоор тусгалаа.

3.Маргаан хянан шийдвэрлэх хугацааг ердийн шүүхийн болон олон улсын туршилагад нийцүүлээ. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд өргөдөл мэдээллийг урьдчилан шалгах хугацааг 14 хоног, Цэцийн хуралдаанд бэлдэх хугацааг 30 хоног байхаар заасан нь маргааныг бүрэн гүйцэд бодитой, үндэслэл бүхий шийдвэрлэх боломжийг хязгаарлаж байна гэж судлаачид үздэг юм. Иймд Цэц маргааныг үүсгэснээс хойш 90 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд тухайн маргаан ээдрээ төвөгтэй бол энэ хугацааг 90 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болохоор заасан нь Монгол Улсын ердийн шүүхэд хэрэглэдэг процессын хуулийн дэвшилтэт зохицуулалт төдийгүй олон улсын сайн жишигт нийцнэ гэж үзэж байгаа юм.

4.Цэцэд хандаж өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргахад хугацааны хязгаарлалт тогтоолоо. Цэцэд хандан өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах хугацааг ердийн шүүхийн нийтлэг жишигт нийцүүлэн ялгамжтайгаар

зохицууллаа. Ингэснээр өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах эрх бүхий этгээд Цэцэд хандахдаа илүү хариуцлагатай хандах, Цэцийн үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлэхээс гадна парламентаас баталсан хууль тогтоомжийг хүндэтгэх, түүний тогтвортой байдал легитим шинжийг хангах ач холбогдолтой юм.

5.Цэцэд ирсэн өргөдөл мэдээллийн анхны буюу хэлбэрийн шалгалтыг ерөнхий бүртгэгч хийх тогтолцоог тусгалаа. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дагуу Цэцийн дарга өргөдөл мэдээллийг Цэцийн гишүүнд хуваарилж, маргаан үүсгэх эсэх асуудлыг нэг гишүүн дангаар шийдвэрлэж, гомдол гаргасан тохиолдолд Цэцийн бага суудлын хуралдаанаар шийдвэрлэж ирсэн. Харин хуулийн төсөлд Цэц нь үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэх маргаан үүсгэх эсэх асуудлыг Цэцийн бага суудлын хуралдаанаар шийдвэрлэдэг байхаар шинэлэг зохицуулалт тусгасан. Түүнчлэн өргөдөл мэдээллийг бага суудалд хуваарилахаас өмнө хуульд заасан шаардлага хангасан эсэхийг нягтлан үзэх, хэлбэрийн хувьд нягтлан үзэх үүрэг бүхий ерөнхий бүртгэгчийг ажиллуулж, Цэцэд хандаж буй иргэнийг чирэгдлээс хамгаалах, нөгөө талаас Цэцийн гишүүнийг шаардлагагүй ачааллаас хөнгөлөх боломжийг нэмэгдүүлнэ гэж үзлээ.

Ерөнхий бүртгэгч нь хуульчийн зөвшөөрөлтэй, мэргэжлээрээ 7-гоос доошгүй жил ажилласан байх бөгөөд Цэцэд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хуульд заасан хэлбэрийн шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авахаас татгалзаж, буцаах шийдвэр гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Иргэн өргөдөл, мэдээллийг хүлээн авахаас татгалзах тухай ерөнхий бүртгэгчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцэд дахин гаргах эрхийг хуульчилж, Цэцийн бага суудлаар шийдвэрлэхээр хуулийн төсөлд тусгалаа.

6.Өргөдөл, мэдээлэл, хүсэлт, маргааныг урьдчилан мэдэх боломжгүй санамсаргүй тохиолдлоор хуваарилах болон холбогдох бусад журмыг баталж хэрэгжүүлэхээр заалаа. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнийг томилох, өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцийн гишүүнд хуваарилах, бүрэлдэхүүнийг томилох асуудлыг Цэцийн дарга шийдвэрлэхээр хуульчилсан нь заримдаа үзэмжээрээ хандах, гишүүдийн ажлын ачаалал хэт ялгаатай болох хараат бус байдалд нь нөлөөлөх эрх зүйн хийдлийг бий болгож байгаа тухай судлаачид шүүмжилдэг.

Түүнчлэн Венецийн комиссоос маргааныг танхимуудад хуваарилах эсвэл бүрэлдэхүүнд хуваарилахдаа нэг талыг баримтлуулахаас зайлсхийх тодорхой журамтай байх шаардлагатай бөгөөд хэргийг автоматаар хуваарилах нь компьютероор хуваарилах нь танхим эсхүл шүүгчийн мэргэшлийн, тооцож чадах учир дээрх шаардлагад хүрэх хамгийн зөв арга гэж зөвлөдөг юм. Иймд олон улсын сайн туршилага болон Шүүхийн тухай хуулийн нэгэнт туссан дэвшилтэт зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаж, өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг бага суудалд хуваарилах, бага, дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох журамтай байх, уул журам нь урьдчилан мэдэх боломжгүй санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан программ хангамжийг ашиглахаар заасан зохицуулалтыг тусгалаа. Ингэснээр эдгээр асуудлыг шийдвэрлэхэд үзэмж, дур зоргоор хандах боломжгүй болж, Цэцийн гишүүний хараат бус байдал, Цэцийн бие даасан, процессын шударга байдлыг нэмэгдүүлэх, Цэцийн гишүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх ач холбогдолтой юм.

Түүнчлэн маргаан үүсгэх эсэх асуудлыг Цэцийн нэг гишүүн дангаар шийдвэрлэдэг байсныг халж, олон улсын

сайн туршилагад үндэслэн бага суудлаар 3 гишүүний бүрэлдэхүүнтэй шийдвэрлэж байхаар хуулийн төсөлд тусгалаа.

7.Цэцийн шийдвэр, түүний үндэслэлийг бичих хугацааг тодорхой зохицууллаа. Цэц Үндсэн хуулийг хэрэглэхдээ хууль тайлбарлах аргыг оновчтой хэрэглэж, тэр дундаа Үндсэн хуулийг үзэл санааны хувьд тайлбарлаж, шийдвэрийг шийдвэрийн үндэслэлээ бичвэл Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа бэхэжнэ гэж үзэж байгаа юм. Өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар Цэц дүгнэлтээ ёсчилсноос хойш 24 цагийн дотор Улсын Их Хуралд хүргүүлэхээр зохицуулж, хэт богино хугацаа өгч байгаа нь Цэцийн дүгнэлтийн үндэслэл товч бичигдэхэд нөлөөлж байгаа юм. Иймд Цэцийн хуралдаан болсноос хойш 14 хоногийн дотор илтгэгч гишүүн эсвэл бүрэлдэхүүний томилсон өөр гишүүний шийдвэрийг шийдвэрийн үндэслэлийн төслийг боловсруулж, бүрэлдэхүүнд танилцуулах, бүрэлдэхүүн 14 хоногийн дотор зөвлөлдөх хуралдаанаар уг төслийг хэлэлцэж, бусад гишүүний саналыг тусгаж эцэслэн, шаардлагатай гэж үзвэл 14 хоногоор сунгах буюу үндсэндээ 45 хоногийн хугацаанд шийдвэрийг эцэслэн бичих зохицуулалтыг орууллаа. Энэ нь Цэцийн шийдвэрийн онолын түвшинд ойлгомжтой, үндэслэлтэй гаргах нөхцөлийг бий болгоно гэж үзэж байгаа юм.

8.Цэц Үндсэн хууль зөрчсөн хууль, бусад шийдвэр, тэдгээрийн холбогдох зүйл, заалтын үйлчлэлийг түдгэлзүүлэхээр тусгав. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн хууль бусад шийдвэрийн түдгэлзүүлэх зохицуулалт байхгүйгээс зөрчилдөөнтэй хууль, бусад шийдвэр, тэдгээрийн холбогдох зүйл, заалт нь үйлчилж, эрх зүйн зөрчил бий болох эрсдэлийг дагуулдаг. Иймд Цэц маргаантай асуудлыг хянан шийдвэрлэх болон ёсчлох хугацааг ялгаатай тусгаж, хуралдаан, зөвлөлдөөний шийдвэрийн агуулга, тогтоох хэсгийг нийтэд

мэдээлснээр Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн хууль, бусад шийдвэр, тэдгээрийн холбогдох зүйл, заалтын үйлчлэлийг Цэцийн эцсийн шийдвэр гаргах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэхээр, түдгэлзүүлэх боломжтойгоор зохицуулж байна. Түүнчлэн ийнхүү түдгэлзүүлсэн хууль, бусад шийдвэр, тэдгээрийн холбогдох зүйл, заалтын талаарх мэдээллийг Улсын Их Хуралд 24 цагийн дотор бичгээр хүргүүлэхээр хуулийн төсөлд тусгалаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Мөнх-Оргил гишүүнд баярлалаа. Хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр ҮХЦ бол энэ Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих, тэр дотроо нөгөө ардчиллынхаа зарчмууд, хүний эрхийн зарчмууд зөрчигдсөн тохиолдолд эцсийн шийдвэр гаргах ийм гол байгууллага. Манай судлаачид, эрдэмтэд мөн энэ Үндсэн хуулийн хяналтын объект нь их хязгаарлагдмал байдаг. Тийм учраас зөвхөн хэм хэмжээний төрийн гол байгууллага, албан тушаалтнуудын үйл ажиллагаа хууль зөрчсөн үү, үгүй юү, эсвэл хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын шийдвэр хэм хэмжээ нь Үндсэн хууль зөрчсөн үү гэдгийг шийдэх буюу их явцуу хүрээнд хяналт тавьдаг гэж шүүмжилдэг. Тэгэхээр энэ ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ҮХЦ-ийн хяналт тавих объектыг нэмэгдүүлж байгаа нь үнэхээр сайшаалтай байгаа.

Тэр дотроо тухайлбал бид нар өнгөрсөн 10-аад жилийн хугацаанд манай эрдэмтэн судлаачид хүний эрхийн зөрчлийг үндсэн эрхийн зөрчлийг Цэц хянан шийдвэрлэхгүйн улмаас ер нь прокурорын болон шүүхийн процедурын явцад асар их зөрчигдөж байна, гомдлууд их ирдэг гэж шүүмжилж байгаа. Манай бас Хүний эрхийн дэд хороонд ирж байгаа гомдлуудын нэлээд хэсэг нь

дандаа энэ прокурорын шатдаа хүний эрхийн зөрчлүүд байсан. Тэгэхээр одоо энэ болгоныг маань ҮХЦ хүний үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэх болж байна. Үнэхээр дэвшилттэй, бас Монгол Улсын энэ өнгөрсөн 30 жилийн практик дахь томоохон хүний эрхийн зөрчлийг энэ шийдвэрлэх том алхам болж байгаа нь үнэхээр зүйтэй байгаа.

Тэгээд энэ нэг ийм асуулт байгаа. Энэ төслийн маань энэ юунууд дээр Монгол Улсын Үндсэн хуульд заасан Үндсэн хуулийн 16 дугаар бүлгийн хүний эрхийн тодорхой заалтууд бол үндсэн эрхийн маргаан гэдгээрээ Цэцэд хянан шийдвэрлэх боломжтой байгаад байгаа. Тэгээд энэ дотор нэг ганц, хоёр заалт буюу 16.5 дугаар заалт, 16.6 дахь заалтууд буюу тухайлбал нөгөө өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэх асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй гэдэг энэ 5 дахь заалт, мөн 6 буюу эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй гэдэг энэ заалтууд бол яг энэ үндсэн эрхийн маргаандаа бол орохгүйгээр энэ төсөлд бол бичигдсэн байна. Энийг үндсэн эрхийн маргаандаа оруулж болохгүй юу гэдгийг асуумаар байна.

2 дугаарт нь энэ мөн энэ Үндсэн хуулийн шүүхээр мэргэшсэн эрдэмтдийн нэг гол шүүмжилж ирсэн зүйл нь ҮХЦ-ийн дунд болон их суудлын хуралдааны шийдвэрүүд, түүнд гаргаж байгаа үндэслэлүүд нь ихэнхдээ маш товчхон, олон нийтэд ойлгомжгүй, ямар үндэслэл, ямар судалгаа, ямар дүгнэлтээр гарсан гэдэг нь их ойлгомжгүй байдаг. Тийм учраас яг иргэд, олон нийтийн хувьд энэ ҮХЦ-ийн дүгнэлтийн талаар мэдээлэл авах боломж их хомс байдаг. Уг нь болбол энэ ҮХЦ-ийн энэ суудлын хуралдаануудын дүгнэлт, үндэслэл бол маш тодорхой байж, тэр нь Улсын Их Хурал тэр дунд суудлын хуралдааны шийдвэрийг эргэн харах гэдэг юм уу эсвэл тодорхой хууль дахь энэ алдаа гаргасан энэ процедураа засахад их дөхөм болдог.

Тэгвэл энэ яг энэ Үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэх хуулийн төсөл дээр энэ Цэцийн их болон дунд суудлын хуралдааны шийдвэр дэх үндэслэлүүдийг хэрхэн тодорхой томъёолж өгөх тухайд ямар заалтууд орж байгаа вэ?

Түрүүн бол энэ ҮХЦ-ийн тухай хуульд орсон өөрчлөлтөөр ҮХЦ маань дэргэдээ номын сан болон бусад эрдэм шинжилгээний юунуудтай байна гээд тодорхой асуудлаар мэргэшсэн дүгнэлт гаргах, судалгаа шинжилгээнд үндэслэх тухай ийм дэвшилүүд орж байгаа. Тэгвэл ҮХЦ-ийн шийдвэрүүд дэх үндэслэлийн талаар ямар дэвшилттэй заалтууд ер нь орж байгаа вэ? Тэгээд ер нь манай энэ Үндсэн хуулийн Цэц маань иргэдийн үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэнэ гэдэг болбол үндсэндээ бараг энэ Цэцийн ачааллыг маань асар нэмэх нь. Тэр Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Үндсэн хуулийн шүүх гэдэг юм уу, Европын холбооны энэ Үндсэн хуулийн.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Мөнхцэцэг гишүүний микрофоныг нэг минутыг нь өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ Европын холбоо болон дэлхийн Үндсэн хуулийн шүүхүүдийн хянан шийдвэрлэдэг маргааны чинь бараг 80, 90 хувь нь дандаа хүний эрхийн зөрчил гомдол л байдаг. Тэгэхээр энэ чиглэлээр хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн эсвэл хүний эрхийн чиглэлийн судалгаа дүгнэлтүүдийг манай ҮХЦ илүү тулж ажиллах шаардлагатай байна. Ялангуяа тэр прокурорын болон хэрэг бүртгэх шатан дахь, эрүүгийн шатан дахь хүний эрхийн зөрчлүүд дээр илүү мэргэшсэн хуульч, шүүгчдийг ажиллуулах шаардлага байна. Энэ тал дээр бас тодорхой ямар зохицуулалт орж байгаа вэ?

Д.Цогтбаатар: Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Сүүлчийн асуултаас нь хариулаад явчихъя. Энэ үндсэн эрхийн маргааныг ҮХЦ дээр хэлэлцдэг болох энэ хуулийн дэвшилтэт заалтыг Улсын Их Хурал дэмжээд хууль батлагдвал энэ хуулийн зохицуулалт 2025 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ гэж бид нар Дагаж мөрдөх хуулийн журамдаа оруулж байгаа. Яагаад гэвэл цаг хугацаа хэрэгтэй, бэлтгэл ажил хэрэгтэй 1 дүгээрт.

2 дугаарт та сая 70, 80 хувь гэж байна, бүүр тэрнээс их хэмжээнд очно. Цэцийн үндсэн ажил бол ер нь 90, 95 хувь нь бол үндсэн эрхийн маргааныг л хэлэлцэнэ. Хийсвэр маргаан бол их бага орж ирнэ. Энэ хуулийн төслийг хэлэлцэж байхад ерөөсөө хийсвэр хяналт буюу abstract review-г ерөөсөө больчихъё. Хүн өөртөө хамаатай л асуудлыг Цэцэд оруулж байя гэдэг тийм санал их гарсан л даа. Тэгээд бид нар нэгэнт манай 30 жилийн практикт Цэц маань зөвхөн хийсвэр хяналт тавиад ирчихсэн учраас иргэд энд дасчихсан учраас энийг нь хэвээр нь үлдээе. Дээр нь үндсэн эрхийн маргааныг нь нэмье гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол Цэцийн үйл ажиллагаанд маш их өөрчлөлт орно. Таны саяын хэлж байгаа тэр хуульчдад тавигдах шаардлага, судлаачид, прокуроруудын үйл ажиллагаанд их өөрчлөлт гарна. Энэ хэцүү ажил, жигдрэх гэж нэлээн их цаг хугацаа гарна. Маш их шүүмжлэл дагуулна. Цэцийг ч гэсэн их шүүмжилнэ, шүүхийг ч гэсэн шүүмжилнэ.

Гэхдээ миний бодлоор бол бид нар энэ шинэчлэлийг хийх цаг нь бол болсон. Энэ шинэчлэлийг хийж байж Цэц маань жинхэнэ утгаараа Үндсэн хуулийн манаач болно. Үндсэн хууль гэдэг бол ерөөсөө хоёрхон зүйлийг л зохицуулж өгч байгаа шүү дээ. Хүн ямар үндсэн эрх, эрх чөлөөтэй юм бэ, төрийн тогтолцоо ямар байх ёстой юм бэ гээд энэ 2-ыг л гэсэн. Гэтэл бид нар энэ нөгөө хийсвэр зохицуулалттай байгаад байгаа өнөөдөр

ҮХЦ бол зөвхөн төрийн тогтолцооны л асуудлыг яриад байдаг. Үндсэн эрх, хүнд оногдсон төрөлхөөс заяасан тэр үндсэн эрх, эрх чөлөө нь хамгаалагдаж байна уу, үгүй юү гэдэг Цэцэд хамаагүй асуудал болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол ингээд Цэцийн үйл ажиллагааны 90 хувь нь бол үндсэн эрх, эрх чөлөө хамгаалах асуудал руу чиглэгдэнэ. Тэгэхдээ дахиад хэлье энэ бол маш их төвөгтэй, асар их ажил, чимхлүүр ажил. Сургалт, тал талаасаа харилцан ойлголцох, хүлээн зөвшөөрөх ажил хийгдэнэ.

Гэхдээ энэ дээр нэг баярлууштай юм бол Монгол Улсын Дээд шүүх энэ хуулийн төслийг нийт шүүгчдийн зөвлөгөөнөөрөө хэлэлцээд, хуулийн төслийг бүхэлд нь дэмжиж байгаа. Манай шийдвэрийг Цэц хэлэлцээд Дээд шүүхийн шийдвэр хүний эрх зөрчсөн байна гэдэг асуудал Цэц Дээд шүүхэд тавих юм бол бид нар хэлэлцэнэ. Хэлэлцэхдээ Цэцийн дүгнэлтийг хүндэтгэлтэй хандаж хэлэлцэнэ гэдгийг бол хүлээн.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Мөнх-Оргил гишүүний микрофоныг нэмээд өгье.

Ц.Мөнх-Оргил: Тэгэхдээ мэдээж Дээд шүүхийн дотроо янз янзын саналтай л хүмүүс байгаа байх. Тэгэхдээ Дээд шүүхийн нийт шүүгчдийн зөвлөгөөнөөс албан ёсоор Ерөнхий шүүгчийн гарын үсэгтэй ирсэн бичиг дээр бол энэ бол зөв дэвшилтэт юм, энэ бол шүүхийн шийдвэрийг эргэж харж байгаа биш Үндсэн хуулиар Дээд шүүх гаргасан шийдвэрээ эргэж харах бололцоог олгож байгаа заалт юм гэдгийг бол хүлээн зөвшөөрч байгаа юм.

Тэгээд энэ дээр нэг чухал заалт байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуульд заачихсан 30 жил ерөөсөө амилаагүй, бүүр ямар ч амьсгаа ороогүй нэг заалт үлдчихээд байгаа байхгүй юу, ганцхан заалт. Тэр нь ийм заалт байгаа юм. Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн нэг дээр Монгол Улсын Дээд шүүх бол

шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гээд 3-д нь хууль түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар ҮХЦ, УЕП-оос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх гэж бүрэн эрхтэй байхгүй юу. Энэ бол ерөөсөө хэрэгжээгүй. Яагаад гэвэл Цэц хэзээ ч Дээд шүүхэд энэ хүний эрх зөрчигдсөн байна гэж Цэцэд асуудал тавьдаггүй. Яагаад гэвэл Цэцийн хуульд нь тийм эрхийг нь бид нар зааж өгөөгүй. Тийм учраас Үндсэн хуулийн энэ том хүний эрх хамгаалах энэ механизм ерөөсөө хэрэгжээгүй байхгүй юу. Тэгэхээр энийг л бид нар хэрэгжүүлж, амь оруулах гэж байгаа заалт байгаа юм.

Тэр эхний асуултад Мөнхцэцэг гишүүн их чухал асуулт асуулаа. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан нийт 17 үндсэн эрх байж байхад үндсэн энэ Цэцийн хуулиар та нар зөвхөн цөөхөн зарим нэгийг нь огт тусгаагүй байна гэж хэлж байгаа юм. Тэр бол үнэн. Энэ дээр бол Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1, 3, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 15, 14, 15, 16, 17, 18-д заасан үндсэн эрх чөлөө, мөн 4 дүгээр зүйлд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхүүдийг ҮХЦ-ээр хамгаалах заалтыг оруулж байгаа юм. Энэ дурдагдаагүй бусад эрхүүд нь болохоор эдийн засаг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Дахиад нэмээд өгчихье, микрофон Мөнх-Оргил сайдын.

Ц.Мөнх-Оргил: Саяын энэ хуульд миний уншаад заачихсан байгаа уншсан Үндсэн хуулиар ҮХЦ-ээр хамгаалуулна гэж байгаа эрхүүд нь бол иргэн улс төрийн эрхүүд, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, жагсах цуглах тийм ээ энэ эрхүүд, тусгаагүй байгаа 3, 4 эрх нь болохоор эдийн засаг, нийгмийн эрхүүд, тэгээд энэ ялгаа нь болохоор олон улсынхаа практикаар ч гэсэн, манай Үндсэн хуулийнхаа үзэл санаагаар ч гэсэн иргэний улс төрийн эрхийг төр бол заавал хангана. Энэ бол хангах үүрэг бүрэн хүлээж байгаа юм. Эдийн засаг, нийгмийн эрх дээр бол төр

хангах талаар хүчин чармайлт гаргах үүрэгтэй. Нэг нь бол obligation result буюу үр дүн гаргах үүрэг, нөгөөдөх нь хүчин чармайлт гаргах үүрэг. Тэгэхээр энийг бол ялгаж салгаж өгч ингэж гаргаж байгаа юм.

Тэгээд энэ бусад орнууд их айхтар байдаг юм байна. Германд бол жишээ нь үндсэн эрх гэхээд зөвхөн улс төрийн эрхүүдийг тусгасан байгаа байхгүй юу. Нийгэм, эдийн засгийн эрхүүдийг бол Үндсэн хуульд ерөөсөө тусгаж өгөөгүй байгаа байхгүй юу. Цэц нь ч гэсэн нийгэм, эдийн засгийн эрхийн хамгийн наад захын юм байна уу, үгүй юү гэдгийг л үзэж байгаа болохоос биш тэр эрхийг улс төрөөс ханга гэдэг асуудлыг бол Цэц дээрээ ерөөсөө Дээд шүүх дээрээ, ҮХЦ дээрээ ярьдаггүй. Тэгэхээр ингэж эхний ээлжидээ салгаж өгөх нь бол зөв зохимжтой бөгөөд эхний ээлжид энэ улс төр иргэний эрхийг баталгаажуулах асуудал чухал байгаа юм.

Д.Цогтбаатар: Үндэслэл тэр асуултад нь нэмээд, гүйцээгээд хариулъя. Мөнх-Оргил гишүүний микрофоныг.

Ц.Мөнх-Оргил: Цэцийн шийдвэрүүд үндэслэлгүй гарч байна гээд судлаачдаас гадна бид нар Их Хурал дээрээ ч гэсэн байнга л ярьдаг зүйл шүү дээ тийм ээ. 2 хуудас бичиг, 10 хуудас үндэслэл гараад ирэхээр тэр тэгж хэлсэн, Улсын Их Хурал ийм хариулт өгсөн, Цэц ингэж шийдлээ гээд л ерөөсөө 2 мөр биччихдэг. Яг Цэц яагаад тэгж шийдсэн гэдэг нь ерөөсөө гарч ирдэггүй. Тэгээд тэрнээс болоод Улсын Их Хурал дараа нь дараагийн хуулиа батлахдаа нөгөө өмнөх гарсан шийдвэрийнх нь үндэслэл нь гарч ирэхгүй болохоор хууль тогтооход их хүндрэлтэй болчоод байдаг.

Тэгээд тэр юунаас болоод байна вэ гэхээр ерөөсөө хоёрхон юмнаас болоод байгаа юм. 1 дүгээрт маргаан үүсгэсний дараа 30 хоногийн дотор Цэц заавал шийдвэр гаргах ёстой болчоод байгаа байхгүй юу. Ямар ч асуудал байсан гэсэн

тэрийг 30 хоногийн дотор л шийдээд дуусна. Шийдвэрээ гаргачхаад 24 цагийн дотор Улсын Их Хуралд өгнө гэхээр Цэц чинь нөгөөдхөө үндэслэлээ онолын үндэслэлээ бичих цаг хугацаа гарахгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо бол бид нар энэ, энийг бол Цэцийн гишүүд байнга хэлж байгаа юм. Үгүй ээ үгүй бид нар үндэслэлээ хэлье, онолоо бичье, тайлбарлая гээд ингэхээр 24 цагийн дотор үндэслэлээ гаргаад Их Хуралд явуулна гэхээр чинь амжихгүй болчихоод байна шүү дээ гээд. Тэгэхээр одоо бол бид нар хугацааг нь тавьж өгч байгаа юм. Одоо бол маргаан үүсгэснээс 90 хоногийн дотор, маргаан үүсгэсний дараа 90 хоногийн дотор асуудлаа шийд. Үнэхээр ээдрээтэй асуудал байх юм бол ахиад 90 хоногоор сунга. Шийдвэрээ амаар гаргаад, амаар гаргаад тэр амаар гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг бичихдээ 14 хоногийн хугацаа авна, шаардлагатай гэвэл ахиад 14 хоногоор.

Манай Монгол шиг шүүхийн шийдвэр амаар хэлэнгүүтээ тэр дор нь бичгээр гаргадаг шүүх дэлхий дээр хаана ч байхгүй шүү дээ. Байхгүй. Амаар шийдвэр гаргалаа Английнх ч байна уу, Америкийнх ч байна уу, Японых ч байна уу амаар шийдвэр гаргалаа энэ хүний гэм буруутайг тогтоолоо, тэдэн жилийн ял өглөө. Бичгээр гарах шийдвэр нь болохоор 2 сар, 3 сар, 6 сарын дараа бичгээр гарч ирж байгаа байхгүй юу. Шүүхийн шийдвэр гарсан уу, гарчихсан. Үндэслэл нь бол араас нь ирж байгаа байхгүй юу. Тэгээд бид нар ингээд нөгөө хугацаагаар шахаад байдаг болохоор шүүгч нар үндэслэл бичих ерөөсөө бололцоогүй болчихоод байдаг. Ерөөсөө хугацаа байхгүй. Тэгэхээр энэ хугацааг нь бид нар сунгаж өгч байгаа юм. Одоо бол бид нар Цэцээс гарч байгаа шийдвэрийнхээ онолын болон практик үндэслэлийг дэлгэрэнгүй бич гэж шаардлага тавих бид нарт эрх байгаа юм, хугацаатай болж байгаа учраас.

Д.Цогтбаатар: Би асууна. Мөнх-Оргил сайд нэг ийм юу байна гишүүнээ. Наадах чинь яах аргагүй аягүй онолын

жинхэнээсээ аягүй том суурь өөрчлөлт аваад ороод ирж байна л даа. Энэ бол жижиг өөрчлөлт биш байхгүй юу. Тийм манайх бол ҮХЦ-ээ шүүх гээд үзээд явж байсан ч нөгөө judiciary буюу одоо энэ эрх мэдэл хуваарилах онолоор байгаа шүүх засаглал чинь бол бас яг биш байхгүй юу. Яагаад гэвэл шүүх засаглал гэдэг чинь бол бүүр яг мэргэжлийн, мэргэжлийн, мэргэжлийн байхгүй юу. ҮХЦ гэдэг бол нөгөө Үндсэн Хуулийг хэлэлцэж байгаа бөгөөд энэ дотор чинь аягүй их улс төрийн companion байгаа учраас Үндсэн хуулийг бүүр бүрэлдүүлэхдээ хүртэл цэвэр мэргэжлийн хуульчдаас биш, улс төрийн эрдэмтэн судлаачид эд нар гээд тавьж байгаа шалгуурууд хүртэл өөр байгаад байгаа шүү дээ. Тэр утгаараа judiciary биш байхгүй юу уг нь.

Гэтэл одоо энэ чинь бол дефакто, яах аргагүй Дээд шүүхийн эцсийн шийдвэрийг гаргадаг Дээд шүүх болох гээд байна шүү дээ. Одоо ялангуяа энэ 17 дугаар зүйл байх шиг байсан, 56 дугаар зүйл байх шиг байсан. Энүүгээр ингээд орж ирж байгаа үйлчлэлүүд чинь яг тэгж хэлээгүй байгаа ч гэсэн эцсийн дүндээ Дээд шүүхийнхээ үүрэг ролийг өөр лүүгээ авчхаж байгаа юм. Яагаад гэвэл сая та өөрөө бас хэлж байна. Ихэнх юу бол гомдол бол Дээд шүүх рүү явна. Наадах чинь бол биш ээ, ҮХЦ рүү явна. Тэгээд ҮХЦ дээр очоод уг нь бол ийм асуудал гарлаа гэхэд цэвэр хуулийн асуудлыг нь хэлэлцээд, тэр нөгөө үндэслэлээ болгож барьж шүүхийн тогтолцоонд шийдвэр гаргасан шийдвэр нь тэр үндэслэл нь болсон хууль нь Үндсэн хууль зөрчихөөд байна гээд энэ нь хуулиа зас гэж байгаа бол нэг асуудал. Наадах чинь бол одоо өргөдлийн дагуу бол бүүр яг хувь хүний асуудлыг шийдэж эхэлж байна шүү дээ. Тэгээд шүүх шийдвэрээ өөрчлөх юу чиглэлийг Дээд шүүх рүү явуулахаар байгаа байхгүй юу.

Хэрэв түүнээс бол хууль нь болохгүй байна гээд Их Хурал руу энэ хуулийг нь засах ёстой гээд явуулж байгаа тэрнээсээ болоод үр дагавар гараад одоо жишээлбэл Дээд шүүхийн

шийдвэр хэрэгжихгүй тэр хуулийг өөрчлөгдтөл түр зогсож байгаа эд нар бол өөр асуудал. Наадах чинь Дээд шүүхийн шийдвэрийг өөрчлөх шийдвэр явж эхэлж байгаа байхгүй юу. Ингэнгүүт наадах чинь өөрөө Дээд шүүх болчхож байгаа юм биш үү? Хэрэв дээд, би тэрийг нэг их эсэргүүцэх гээд байгаа биш. Асуудал чинь юу болоод хувирч байгаа вэ? Хэрэв Дээд шүүх болж байгаа бол наад ҮХЦ-ийн гишүүдийн чинь асуудал өөр болоод явчхаж байгаа байхгүй юу. Яагаад гэвэл хувь хүний яг жишээлбэл ялангуяа эрүүгийн гэмт хэрэг эд нартай холбоотой асуудлууд дээр бол яах аргагүй мэргэжлийн, мэргэжлийн хүн л энэ шийдвэрүүдийг гаргаж байхгүй бол наадах чинь санал хураалтаар бүрэлдэхүүнтэй шийдээд явахаар чинь шийдээд явна. Цаана нь улс төрийн companion энэ рүү орох гэж байгаа байхгүй юу. Тэгтэл эрүүгийн асуудал дээр улс төрийн companion ерөөсөө байж болохгүй. Ингээд энэ чинь өөрөө нэг ийм яриан дунд дээд, ҮХЦ юу улс орны асуудал шийдэж байгаа ийм шүүх чинь энэ хэмжээний асуудлыг шийдчихгүй яах юм бэ гэж хүн бодоод зүгээр хандаад байж магадгүй. Гэтэл жинхэнэ тавигдах тэр шаардлагууд чинь огт өөр болчхоод байна л даа. Энэ дээр та хэд маань ярьсан уу? Наадах чинь миний хувьд бол яах аргагүй ийм эргэлзээ төрүүлээд эхэлж байгаа юм л даа. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Тийм, тийм. Энэ их явдалтай ээдрээтэй, тэгээд онолын ч болон практикийн маргаантай асуудлууд их гарна л даа. Ер нь бол 92 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш л ҮХЦ-д үндсэн эрхийн маргааныг харьяалуулах уу, үгүй юү гэдэг маргаан эхнээсээ шууд гараад л эхэлсэн л дээ. Тэгээд 30 жилийн туршид бол Цэцээ бэхжүүлэе, Дээд шүүхийнхээ шийдвэрийг хүлээцтэй хандъя гээд л ингэж хойшлуулсаар байгаад л өнөөдрийг хүрчхэж байгаа юм. Тэгээд бид нар бол юу гэж үзэж байгаа вэ гэхээр үндсэн эрхийн маргаан зөвхөн үндсэн эрхийн маргаан, зөвхөн тэр хүнд хамааралтай, тэр улс төрийн

тогтолцооны асуудал, улс төрийн маргаан энд бол ерөөсөө хамаагүй. Зөвхөн тухайн хүнд хамааралтай хувь хүний Үндсэн хуульд заасан эрх зөрчигдсөн, Үндсэн хуульд заасан үндсэн эрх зөрчигдөхдөө түрүүний миний хэлсэн иргэн улс төрийн эрхүүд л хөндөгдсөн асуудлыг л энэ хүн шүүхийн бүх шат дамжлагаараа дуусаад, жишээ нь Захиргааны шүүхээр явсан бол Захиргааны шүүхээрээ яваад дуусаад бүх гомдлоо барагдуулсны дараа л Цэцэд гаргах эрх нь үлдэж байгаа юм. Цэцэд гаргах эрх нь үлдэж байгаа юм.

Тэгэхээр энэ та түрүүн яг зөв хэллээ л дээ. Энэ Үндсэн хуулийн шүүх гэдэг бол манайд ч гэсэн тэр, бусад оронд ч гэсэн тэр яг ердийн шүүх бас биш. Энэ бол Үндсэн хуулийн шүүх болчхоод байгаа байхгүй юу. Тэгэхээр улс төрийн юу орж ирнэ. Улс төрийн асуудал орж ирэхдээ үндсэн эрхийн маргаан дээр орж ирэхгүй. Үндсэн эрхийн маргаан бол тухайн хувь хүний өөрийнх нь асуудал явж байгаа учраас тэр бол яг тэр хүнийхээ хуулиар олгогдсон Үндсэн хуулиар олгогдсон эрх нь хэрэгжиж байна уу, үгүй юү гэдэг тал дээрээ л шийдэгдээд л тэр асуудал дуусна.

Нөгөө нэг Үндсэн хуулиар нөгөө улс төрийн байгууллагуудад, албан тушаалтнуудад нөгөө хүсэлт гаргах эрх олгочихсон байж байгаа шүү дээ тийм ээ. Тэр бол одоогийнхоо процессоор улс төрийнхөө шийдлээр гараад явчихна. Тэгэхээр энэ 2-ын хооронд бол ингээд зааг гарч байгаа юм. Гэхдээ энэ дээр бол өөр олон юу гэдэг юм бэ дээ маргаантай асуудлууд гарна л даа. Жишээ нь шүүхийн шийдвэр гарчихсан байхад ҮХЦ-д хандчихлаа. Тэгэхээр шүүхийн шийдвэрийн ямар хэсгийг нь түдгэлзүүлээд, ямар хэсгийг нь хэрэгжүүлээд явж байх ёстой юм. Хэрэгжүүлчихсэн байхад Цэцийн шийдвэр гараад, Цэцийн шийдвэрийг Дээд шүүх хүлээж аваад тийм байна бид нар үнэхээр хүний эрх зөрчсөн шийдвэр гаргачихсан байна гээд Үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу Дээд шүүх

шийдвэрээ өөрчилчихлөө гэж бодлоо шүү дээ тийм ээ, тэр шийдвэрээ өөрчлөгдчихөд хэрэгжихсэн шийдвэр нь яах вэ, аль хэсэг нь дахиж эргээж харагдах ёстой юм, аль хэсэг нь эргээж харагдахгүй ингээд. Жишээ нь ганцхан шийдвэр гүйцэтгэл гэхэд л маш олон асуудлууд гарч байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бид нар энэ 25 оны 1 сарын 1 гэж энэ хугацаа авч байгаа энэ хооронд бол энэ шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бол цэгцэлнэ.

Процесстой холбоотой асуудлуудыг бол сая бид нар ажлын хэсэг дээр яриад, хуулийн төслүүдийг нь боловсруулаад, Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцүүлээд, зөвшөөрлийг нь авчихсан, энэ байж байгаа юм. Энэ дээр бол 2 асуудал гарч.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Энэ дээр 2 асуудал гарч ирж байгаа юм. Жишээ нь шүүгч хүчин төгөлдөр болчихсон хуулийн дагуу хүний асуудлыг шийдэх гэж байна гэж бодъё тийм ээ. Тэгтэл тэр хүн өөрөө үгүй ээ энэ хууль чинь өөрөө Үндсэн хууль зөрччихсөн байна шүү дээ гэж шүүгчийн итгэл төрж болно шүү дээ. Тэгэх юм бол Дээд шүүхийнхээ танхимаар холбогдох танхимаараа дамжуулаад Цэцэд асуудал гаргана. Тэгээд Цэц энэ асуудлыг нь үзээд Үндсэн хууль зөрчсөн байна гэх юм бол тэр хүн тэр Үндсэн хууль зөрчөөгүй болгосон хуулиар асуудлыг шийднэ. Энэ бол ингээд нэг талаасаа.

Нөгөө талаасаа шүүгч өөрөө тэгж бодоогүй ч гэсэн тэр шүүгч тэгж бодоогүй, тэгээд шүүхийн шийдвэр нь гарчихлаа. Ингээд Дээд шүүхээрээ ч юм уу, давж заалдах шатны шүүхээрээ яваад шийдвэр гараад дууслаа шүү дээ. Энэ үед хүн үгүй ээ үгүй миний Үндсэн хуулиар олгогдсон эрх бүх шатны шүүхээр яваад ч гэсэн хэрэгжсэнгүй. Би одоо энэ асуудал дээрээ гомдол гаргая гээд гомдол гаргана. 2 дахь хувилбар нь

энэ болж байгаа байхгүй юу. 2 дахь хэлбэр нь. Эхнийх нь болохоор асуудал хэрэглэж байгаа шүүгч нь хууль хэрэглэж байгаа шүүгч нь өөрөө Үндсэн хууль зөрчсөн байна энэ хууль гэдэг хүсэлт тавих, нөгөөдөх нь бүх шатны шүүхийн шийдвэр гарсны дараа асуудал хууль Үндсэн хуулийн зөрчилтэй хэвээрээ байна гэдэг гомдол гаргах 2 дахь хэлбэр нь үлдчихэж байгаа юм.

2 дахь хэлбэр дээр ийм асуудал гарч ирнэ. Давж заалдах шатны шүүх дээр асуудал хэлэлцэгдээд дуусчихсан байх юм бол Цэц асуудал энэ чинь нөгөө шүүхийн бүх шатаар яваад дууссантай адилхан тооцно шүү дээ. Хяналтын шатан дээр очоогүй эсвэл хяналтын шат асуудлыг нь аваагүй байх юм бол давж заалдах шатны шүүхийг нь Цэц хэлэлцье гэж үзэх юм бол хэлэлцээд, үнэхээр зөрччихөөгүй байна гэж үзэх юм бол асуудал байхгүй дуусчихна. Зөрччихсөн байна гэх юм бол Дээд шүүхэд өгнө. Дээд шүүхийн хяналтын шатны шүүх нь үзээд зөрчөөгүй байна гэж үзэх нэг хувилбар, зөрчсөн байна гэж үзэх юм бол буцаагаад энэ зөрчлийг арилгуул гээд давж заалдах шатны шүүхэд нь явуулах, буцаагаад давж заалдах шатны шүүхэд. Өөрийнхөө хяналтын шатны буюу Дээд шүүх өөрийнхөө шийдвэрийг өөрийнх нь гаргасан шийдвэр Үндсэн хууль зөрчсөн байна гээд Цэцийн дүгнэлт ороод.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Микрофоныг нь өгье Мөнх-Оргил гишүүний. Энийг ярихгүй бол үнэхээр болохгүй асуудал байгаа учраас.

Ц.Мөнх-Оргил: Дээд шүүхийн шийдвэр Үндсэн хууль зөрчсөн байна гээд Цэцийн дүгнэлт ороод ирэх юм бол тэрийг Дээд шүүх өөрөө хэлэлцээд зөрчсөн, зөрчөөгүйгээ шийдээд эцсийн шийдвэрээ гаргана. Өөрөөр хэлбэл Цэц Дээд шүүхийн шийдвэрийг хэрэгсэхгүй болгож байгаа юм бол ерөөсөө байхгүй. Үндсэн хуулийн Дээд шүүхийн шийдвэр эцсийнх гэдэг хэвээрээ. Харин Үндсэн хуульд Дээд шүүх өөрийнхөө шийдвэрийг

өөрөө засаж залруулж болно гэдэг тэр заалтыг л ашиглаж байгаа юм. Тэгээд түрүүний нөгөө 50.1.3 дээр Цэц хүний эрх хамгаалах асуудлаар үндсэн Дээд шүүхэд хандаж асуудал тавина гэдэг энэ Үндсэн хуулийн 2 заалт байна шүү дээ тийм ээ, энэ 2-ын зааг дээр л энэ асуудал явж байгаа юм.

Тэгэхээр шүүхийн шийдвэр эцсийнх байдгаараа байна, Дээд шүүхийн шийдвэр эцсийнх байдгаараа байна. Энд нь Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн зөрчил байна уу, үгүй юү гэдэг асуудал дээр Цэц дүгнэлт гаргаад ирэхээр Цэц, Дээд шүүх өөрийнхөө шийдвэрийг эсвэл эргээж харна эсвэл хэвээр үлдээнэ. Ерөөсөө л ийм л зохицуулалт байгаа юм.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Гэхдээ асуудлууд байгаа. Энийг тэгээд цаашдаа хэлэлцүүлгийн явцад яриад явъя. Түүнээс дуусахгүй наадах чинь маргаан явах байх. Миний зүгээр хамгийн гайхаж байгаа юм Дээд шүүх өөрийнхөө бүрэлдэхүүнээр энэ болж байна гээд явуулчихсан байгаа бол одоо бид энд хэлээд байх юм юу байх вэ. Гэхдээ бол энэ чинь өөрөө ардаа асуудалтай л байна гэж би харж байгаа юм. Ингээд хуультай холбогдуулаад санал хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Алга байна. Ингэхээр одоо ингээд хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд санал, асуулт асууж, үгээ хэлж дууслаа.

Ингээд санал хураалт явуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил нарын гишүүд 2024 оны 3 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 60 хувиар санал дэмжигдлээ. Ингээд ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Мөн түүнчлэн түрүүн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг бас хэлэлцүүлгийг явуулж дууссан. Тэгээд юу түрүүн энэ түрүүний санал хураалтын дүн 54,5 хувьтай байсан, саяынх 60 хувьтай байлаа. Ингээд хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны саяын 2 хуулийн төсөл шүү. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан танилцуулна. Хоёуланг нь, тийм. Та чинь өөрөө санаачлаад оруулж байгаа юм чинь. Тийм.

12.35 цаг

Ингээд 3 дугаар асуудалдаа оръё. Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа нарын 19, Одонтуяа гишүүний, Одонтуяа нарын 19 гишүүн 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурал, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлын хэлэлцүүлгийг түр хойшлуулж өгөхийг хууль санаачлагч өөрөө хүссэн учир хойшлууллаа.

Тэгвэл ингээд шууд 3 дугаар асуудалдаа биш ээ, 4 дүгээр асуудалдаа оръё.

Гурав. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Тогтоолын төслийг та бүгдэд тараасан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Энэ чинь нөгөө юуны тухай болохоор тэгвэл албан тушаалтнууд байхгүй байна, байх шаардлагагүй өөрөөр хэлбэл.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү, Байхгүй байна. Ингээд Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёолоор санал хураалт явуулъя. 60 хувиар энэ санал дэмжигдлээ.

Тэгвэл ингээд Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг танилцуулна.

12.37

Дөрөв.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлт

Дараагийн асуудалдаа оръё. 5 дугаар асуудал улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 1 дүгээр дүгнэлтийн асуудал байгаа. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай тухай асуудал байгаа ҮХЦ-ийн 2024 оны 1 дүгээр дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнууд юу байхгүй байгаа юу? тэгвэл энд юу байх шаардлагагүй байж байгаа.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн

Сандаг-Очир гишүүн бас байхгүй байгаа. Тэгэхээр танилцуулгыг нь тийм би танилцуулаад явчихъя энэтэй холбогдсон. Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан хууль дээдлэх зарчмын гол агуулга нь нийт байгууллага, иргэний аливаа үйл ажиллагаа Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байхын зэрэгцээ хуулийн хүрээнд явагдах агуулгыг илэрхийлнэ. Хууль дээдлэх зарчмын суурь болох Үндсэн хуулийг дээдлэх үзэл баримтлал нь дэлхий нийтийн түгээмэл эрхэм дээд үзэл санаа болон хүлээн зөвшөөрөгдсөн байна.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурал Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэж заасан нь сонгогч иргэний төрийн үйл хэрэгт сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан оролцох эрхийг баталгаажуулж, сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн гарааны тэгш байдлыг хангах, сонгуулийн хуулийг тогтвортой мөрдөхөд чиглэсэн байх бөгөөд ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн хугацаанд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхгүй байна.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 6 дугаар сарын сүүлийн хагасын аль нэг ажлын өдөр байна гэж, хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрөөс өмнөх нэг жилийн хугацаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэж тус тус хуульчилсан байна.

Түүнчлэн Улсын Их Хурлаас Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай 2023 оны 116 дугаар тогтоол гарган ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдөр байхаар тогтоожээ. Дээрхээс үзэхэд хууль тогтоогч 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр буюу сонгуулийн сонгууль явагдахын өмнөх нэг жилийн дотор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчиж, хууль дээдлэх зарчмыг алдагдуулсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах.

1. Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй гэсэн 29.3.3 дахь заалт нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар

зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай гэсэн байна.

Ингээд энэ саяын танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Юу энэтэй холбогдуулан асууж, асуулт асууж, хариулт авч дууслаа. Ингээд Цэцийн дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Байхгүй байна. Ингээд Цэцийн дүгнэлттэй холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа. Ингээд санал хураалт явуулъя. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд сүүлийн 6 тийм үү, гишүүд хуралдаа орж ирэхийг хүсэж байна. Юу ч гэсэн би юугаа томъёоллоо танилцуулж байя санал хураах.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд “сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй.” гэж 29.3.3 дахь заалт нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд орж ирэхийг түр хүлээж байя. Түрүүн уншиж танилцуулсан томъёоллоор санал хураалт явуулъя. 60 хувиар санал дэмжигдлээ.

2 дахь санал хураалт байгаа. Яэ энэ асуудлаар бас. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд “сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн

тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй.” гэж 29.3.3 дахь заалт нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “... Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Ингээд 60 хувийн энэ санал дэмжигдлээ.

Ингээд Үндсэн хуулийн цэцийн, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж дууслаа. Үндсэн хуулийн, Монгол Улсын ҮХЦ-ийн 2024 оны 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг танилцуулна. Сандаг-Очир гишүүн маргааш томилолтоос ирчихсэн байх юм байна. Тэгэхээр Сандаг-Очир гишүүн өөрөө танилцуулна.

12.53 цаг

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын

ээлжит чуулганы 3 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Байхгүй байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Байхгүй байна. Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Энийг Мөнхцэцэг гишүүн танилцуулчхаж болно биз дээ. 60 хувиар энэ санал дэмжигдлээ.

12.54 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа, ирж оролцсон гишүүддээ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

